

**ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2026 оны 06 дугаар сарын 30-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-10
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	11-43
1.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг нарын 71 гишүүн 2025.09.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	12-24
2.Асрах үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяа нарын 65 гишүүн 2026.06.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	24-30
3.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн биелэлтэд хяналт шалгалт хийж, холбогдох санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт	31-39
4.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Б.Түвшин нарын гишүүд өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл, эцсийн хэлэлцүүлэг/	39-43

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны
06 дугаар сарын 30-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Ганзориг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 53.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 17 цаг 15 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Бямбасүрэн;

Чөлөөтэй: Ж.Баясгалан, Б.Бейсен, Д.Бум-Очир, Ц.Мөнхтуяа, М.Энхцэцэг.

Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир хэлэлцэх асуудлын дарааллын 3 дугаарт орсон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэх асуудлаас хасаж, хойшлуулах горимын санал гаргав.

П.Ганзориг: Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 6

Бүгд: 18

66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа хэлэлцэх асуудлын дарааллын 1 дүгээрт орсон Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хамгийн сүүлд хэлэлцэх горимын санал гаргав.

П.Ганзориг: Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 6

Бүгд: 18

66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг нарын 71 гишүүн 2025.09.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын мэргэжилтэн Д.Долгорсүрэн, Татварын бодлогын газрын мэргэжилтэн Ж.Төрболд, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, мөн газрын улсын байцаагч Б.Отгонбаяр, Гаалийн ерөнхий газрын Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Чимгэрэл, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын

Суурин төлөөлөгчийн газрын Халдварт бус өвчний урьдчилан сэргийлэлт, хяналтын асуудал хариуцсан мэргэжилтэн С.Болормаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх А.Болортуяа, референт Ц.Долгормаа, Н.Монголмаа, Б.Энхмаа нар байлцав.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Л.Энхнасан, М.Нарантуяа-Нара, П.Наранбаяр нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга П.Ганзориг, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нар хариулж, тайлбар хийв.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ тогтоох тухай тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтыг үндэслэн хураалгах санал:

П.Ганзориг: 1.Төслийн 1 дэх заалтыг бүхэлд нь доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.“Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын хавсралтад доор дурдсан агуулгатай дараах 85.43, 96.14 дүгээр зүйл, үндэсний код нэмсүгэй:

“1/85 дугаар бүлгийн 85.43 дугаар зүйл:

85	85.43	85.43	Энэ бүлгийн бусад газар заагдаагүй ганцаарчилсан зориулалтын цахилгаан машин болон аппарат.	5
		8543.40.00	Электрон тамхи болон түүнтэй төстэй цахилгаанаар ажилладаг ууршуулж татах хэрэгсэл	20
			Эд анги:	
		8543.90.00	Электрон тамхи болон түүнтэй төстэй цахилгаанаар ажилладаг ууршуулж татах төхөөрөмжийн	20
			Бусад	5

2/96 дугаар бүлгийн 96.14 дүгээр зүйл:

96	96.14	9614.00.00	Тамхины гаанс (гаансны толгой орно) болон сигар, янжуур тамхины соруул, тэдгээрийн эд анги.	20
----	-------	------------	---	----

” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 8
Бүгд: 21
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 8
Бүгд: 21
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтыг үндэслэн хураалгах санал:

П.Ганзориг: Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6 дугаар зүйлийн 6.7.16 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.7.16.тамхи татах төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, татах төхөөрөмжийн эд ангид тамхинаас өөр төрлийн үнэр, амт оруулагч бодис нэмсэн байх;” гэсэн саналыг дахин санал хураалгах шаардлагатай гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 6
Бүгд: 21
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6 дугаар зүйлийн 6.7.16 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.7.16.хамрын тамхи, усан хоолойгоор татах зориулалттай тамхинаас бусад тамхи татах төхөөрөмж, түүний эд ангид тамхинаас өөр төрлийн үнэр, амт оруулах бодис, бэлдмэл нэмсэн байх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 6
Бүгд: 21
71.4 хувь буюу гуравны хоёроос дээш саналаар дэмжигдлээ.

П.Ганзориг: Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6.7.17 дахь заалтад доор дурдсан агуулгатай өгүүлбэр нэмэх:

“2010 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр болон түүнээс хойш төрсөн Монгол Улсын иргэнд тамхи, тамхин бүтээгдэхүүн, никотин агуулсан болон никотин хүргэх

зориулалттай бүтээгдэхүүнийг худалдахыг хориглоно. Энэ хэсэгт заасан этгээдэд тамхи, тамхин бүтээгдэхүүн, никотин агуулсан болон никотин хүргэх зориулалттай бүтээгдэхүүн худалдсан, нийлүүлсэн, үнэ төлбөргүй олгосон этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэсэн саналыг дахин санал хураалгах шаардлагатай гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 4
Бүгд: 21
81.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6.7.17 дахь заалтаас доор дурдсан агуулгатай 2 дахь өгүүлбэрийг хасах:

“2010 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр болон түүнээс хойш төрсөн Монгол Улсын иргэнд тамхи, тамхин бүтээгдэхүүн, никотин агуулсан болон никотин хүргэх зориулалттай бүтээгдэхүүн худалдахыг хориглоно. Энэ хэсэгт заасан этгээдэд тамхи, тамхин бүтээгдэхүүн, никотин агуулсан болон никотин хүргэх зориулалттай бүтээгдэхүүн худалдсан, нийлүүлсэн, үнэ төлбөргүй олгосон этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 3
Бүгд: 21
85.7 хувь буюу гуравны хоёроос дээш саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Асрах үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяа нарын 65 гишүүн 2026.06.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан хуульч Д.Оросоо, Б.Төрболд, хуулийн зөвлөх Д.Энхбат, судлаач Б.Батцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх А.Болортуяа, референт Ц.Долгормаа, Н.Монголмаа, Б.Энхмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяа танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаяр, А.Ганбаатар, М.Нарантуяа-Нара нар үг хэлэв.

Хуралдаан 18 цаг 27 минутаас 18 цаг 56 минутад завсарлав.

П.Ганзориг: 1.Асрах үйлчилгээний тухай анхдагч хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 10
Бүгд: 22
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 9
Бүгд: 22
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 9
Бүгд: 22
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 9
Бүгд: 22
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 10
Бүгд: 22
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Асрах үйлчилгээний тухай анхдагч хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 9

Бүгд: 22

59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 19 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат хэлэлцэх асуудлын дарааллын 5 дугаарт орсон Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатаас Боловсролын сайдад хандаж тавьсан Боловсролын салбарын багш, ажилчдын нийгмийн баталгааны талаар асуултын хариуг хэлэлцэх асуудлыг хойшлуулах горимын санал гаргав.

П.Ганзориг: Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 9

Бүгд: 22

59.1 хувийн саналаар горимын санал дэмжигдэж, уг асуудлыг хойшлуулав.

Гурав.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн биелэлтэд хяналт шалгалт хийж, холбогдох санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Ц.Долгормаа, Н.Монголмаа, Б.Энхмаа нар байлцав.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн биелэлтэд хяналт шалгалт хийж, холбогдох санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг, Ж.Чинбүрэн нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун, ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн биелэлтэд хяналт шалгалт хийж, холбогдох санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлттэй танилцав.

Уг асуудлыг 19 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар хэлэлцэх асуудлын дарааллын 7 дугаарт орсон Шинжлэх ухаан, технологийн салбарыг улсын хөгжлийн бодлого, нийгэм, эдийн засаг, инновац, үйлдвэрлэлийн бодлоготой уялдуулан хөгжүүлэх талаарх Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын мэдээллийг сонсох асуудлыг хойшлуулах горимын санал гаргав.

П.Ганзориг: Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 11

Бүгд: 24

54.2 хувийн саналаар горимын санал дэмжигдэж, уг асуудлыг хойшлуулав.

Дөрөв.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Б.Түвшин нарын гишүүд өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх Л.Мөнхзул, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын зөвлөх Г.Саран, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга А.Даваажаргал, мөн яамны Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын газрын дарга Б.Алимаа, Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд, мөн газрын ахлах шинжээч Б.Мөнхбаяр, шинжээч Б.Баянжаргал, Э.Цэрэнбат, ахлах мэргэжилтэн З.Пунцагцэрэн, А.Уртнасан, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, мөн газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны Ерөнхийлөгч Э.Тамир, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны Ерөнхийлөгч Ч.Нанжидсамбуу, мөн холбооны Хөдөлмөрийн харилцаа, эрх зүй, нийгмийн бодлогын газрын дарга Э.Энхжаргал, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх Мэргэжлийн хорооны дарга Д.Далхжав, Санхүү, эдийн засгийн их сургуулийн багш Ч.Өнөржаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Б.Мажигсүрэн, референт Б.Цогзолбаяр нар байлцав.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтыг үндэслэн хураалгах санал:

П.Ганзориг: Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалт буюу 21 дүгээр зүйлийн 21.29 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.29.Сүүлийн таван жилийн дотор нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгүүлсэн таваас ихгүй ажилтантай ажил олгогчийн гурав хүртэл ажилтны ажил олгогчийн төлөх энэ хуулийн 6.1.1, 6.1.2-т заасан нийгмийн даатгалын шимтгэлээс 36 сар хүртэлх хугацаанд, хэрэв ажилтан хөгжлийн бэрхшээлтэй бол 60 сар хүртэлх хугацаанд чөлөөлж болно. Хэрэв ажил олгогч 5 ажилтантай бол 3 ажилтны, 4 ажилтантай бол 2 ажилтны, 2 ба 3 ажилтантай бол 1 ажилтны ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөгдөнө. Энэ шимтгэлийн чөлөөлөлтөд даатгуулагч зөвхөн нэг удаа хамрагдана.”

Тайлбар:Сүүлийн таван жил гэдгийг ажил олгогч шимтгэлийн чөлөөлөлтөд хамрагдах хүсэлтээ нийгмийн даатгалын байгууллагад гаргасан сараас өмнөх 60 сарыг ойлгоно гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 10
Бүгд: 24
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтыг үндэслэн хураалгах санал:

1.Нэгтгэсэн төслийн 2 дугаар зүйлийг 1 дүгээр зүйл болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх өдрөөс өмнө Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгосон 60 насанд хүрсэн эрэгтэй тэтгэвэр авагчид, 55 насанд хүрсэн эмэгтэй тэтгэвэр авагчид олгох суурь тэтгэвэр (C_T)-ийн хэмжээг тооцоход баримтлах үзүүлэлтийг Засгийн газраас тогтоохдоо Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг харгалзах бөгөөд суурь тэтгэврийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 10
Бүгд: 24
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийг 2 дугаар зүйл болгож доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1.8 дахь заалтад заасан суурь тэтгэвэрт шаардагдах хөрөнгийг 2027 оны улсын төсөвт тусгана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 10
Бүгд: 24
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтыг үндэслэн хураалгах санал:

1.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх өдрөөс өмнө Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгосон 60 насанд хүрсэн эрэгтэй тэтгэвэр авагчид, 55 насанд хүрсэн эмэгтэй тэтгэвэр авагчид олгох суурь тэтгэвэр (C_T)-ийн хэмжээг тооцоход баримтлах үзүүлэлтийг Засгийн газраас тогтоохдоо Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг харгалзах бөгөөд суурь тэтгэврийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 10
Бүгд: 24
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 19 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 00 минут үргэлжилж, ирвэл зохих 30 гишүүнээс 24 гишүүн хүрэлцэн ирж, 80.0 хувийн ирцтэйгээр 19 цаг 44 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

П.ГАНЗОРИГ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 06 дугаар сарын 30-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
17 цаг 15 минут.

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

П.Ганзориг: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Байнгын хорооноос ирвэл зохих 30 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 53.3 хувьтай бүрдсэн тул Байнгын хорооны 2026 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Гишүүдийн ирцийг танилцуулъя. Наранцэцэгийн Алтаншагай, Аюушийн Ариунзаяа, Отгоншарын Батнайрамдал, Жанчивын Галбадрах, Амгаланбаатарын Ганбаатар, Пүрэвжавын Ганзориг, Даваасамбуугийн Ганмаа, Мөнгөнцогийн Ганхүлэг, Тогтмолын Мөнхсайхан, Пүрэвсүрэнгийн Наранбаяр, Мөнхтөрийн Нарантуяа-Нара, Дүгэрийн Рэгдэл, Мягмардашийн Сарнай, Жигжидсүрэнгийн Чинбүрэн, Лутаагийн Энхнасан, Сүхбаатарын Эрдэнэбат нарын 16 гишүүн хүрэлцэн ирсэн байна. Банзрагчийн Түвшин гишүүн орж ирлээ. Ингээд 17 гишүүн хүрэлцэн ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар өнөөдөр 7 асуудал хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1 дүгээрт, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Засгийн газар болон Улсын Их Хурал /УИХ/-ын гишүүн А.Ариунзаяа, Б.Түвшин нарын гишүүд өргөн мэдүүлсэн нэгтгэсэн төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулна. 2-т, Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд, УИХ-ын гишүүн О.Номинчимэг нарын 71 гишүүн 2025 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн мөн эцсийн хэлэлцүүлэг. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 5 дугаар сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн төслийн хэлэлцэх эсэх хэсэг. 4-т, Асрах үйлчилгээний тухай анхдагч хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, УИХ-ын гишүүн Д.Энхтуяа нарын 65 гишүүн 2026 оны 6 дугаар сарын 22-ны өдөр өргөн мэдүүлсэн төслийн хэлэлцэх эсэх. 5-д, УИХ-ын гишүүн С.Эрдэнэбатаас Боловсролын сайдад хандаж тавьсан боловсролын салбарын багш, ажилчдын нийгмийн баталгааны талаарх асуулгын хариуг хэлэлцэх. 6-д, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн биелэлтэд хяналт шалгалт хийж, холбогдох санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт. 7-д, Шинжлэх ухаан, технологийн салбарыг улсын хөгжлийн бодлого, нийгэм, эдийн засаг, инновац, үйлдвэрлэлийн бодлоготой уялдуулан хөгжүүлэх талаар Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад мэдээллийг сонсох.

Ийм 7 асуудлыг өнөөдрийн Байнгын хорооны хурлаар хэлэлцэнэ. Тэгээд хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу? Ариунзаяа гишүүн, Аубакир сайд. Ариунзаяа гишүүнээс эхэлье.

А.Ариунзаяа: Өнөөдөр чуулган дээр нийгмийн даатгалын нэгтгэсэн хуулиуд хэлэлцэж хараахан дуусаагүй байна. Ардчилсан нам /АН/ 2 цагийн завсарлага авсантай холбоотой хэлэлцүүлэг жоохон хойшилчихлоо. Ийм учраас энэ 1 дүгээр асуудлыг хэлэлцэх асуудлуудынхаа хамгийн хойно тавих ийм горимын санал гаргаж байна. Хамгийн хойно буюу Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг, хамтарсан төслүүдийг 7 дугаар асуудлаар хэлэлцье.

П.Ганзориг: Аубакир сайд.

Т.Аубакир: Өдрийн мэнд хүргэе. Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг өргөн мэдүүлээд хэлэлцэх эсэх нь шийдэгдэх ёстой Байнгын хороо, УИХ-ын чуулган дээр, эргэж ажиллах шаардлагатай байгаа тул энэхүү хуулийн өнөөдрийн хэлэлцүүлгийг хойшлуулж өгнө үү гэсэн хүсэлт гаргаж байна.

П.Ганзориг: Гишүүдээс гарсан горимын саналтай холбоотойгоор санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлдэнэ үү. Ингээд олон асуудлаас эхлээд хасах асуудлаар санал хураачихъя. Тэгэхээр Засгийн газраас өргөн барьсан 3 дахь асуудал буюу Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хамт хууль санаачлагчаас өнөөдөр хэлэлцэх асуудлаас хасуулъя гэдэг саналын томъёоллоор санал хураалт. Санал хураалтад нийт 18 гишүүн орсноос 12 гишүүн дэмжиж, санал 66.7 хувиар дэмжигдлээ.

2 дахь горимын санал хураалт. Хамгийн эхний буюу Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг өнөөдрийн хэлэлцэх асуудлын хамгийн сүүлийн буюу 6 дахь асуудал болгож дараалалд өөрчлөлт оруулах. Санал хураалт. Санал хураалтад нийт 18 гишүүн орсноос 12 гишүүн дэмжиж, санал 66.7 хувиар дэмжигдлээ.

Нэг.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг нарын 71 гишүүн 2025.09.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Эхний хэлэлцэх асуудалдаа оръё. Эхний хэлэлцэх асуудал УИХ-ын гишүүн Номинчимэг нарын 71 гишүүнээс 2025 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя. Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг бэлэн байгаа юу, танилцуулах уу? Эхлээд ингэе. Байнгын хорооны ажлын хэсгийн танилцуулгыг УИХ-ын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Жигжидсүрэнгийн Чинбүрэн танилцуулна. Чинбүрэн гишүүний микрофоныг нээе.

Ж.Чинбүрэн: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол УИХ-ын гишүүн О.Номинчимэг нарын 71 гишүүнээс 2025 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт,

өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол УИХ 2026 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн.

Монгол УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу зарчмын зөрүүтэй 2 санал дээр гүйцээн боловсруулах чиглэл өгсөн тул Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Импортын барааны гаалийн албан татварын хувь хэмжээ тогтоох тухай тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай УИХ-ын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй 2 саналыг гүйцээн боловсрууллаа.

Мөн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг нэгдсэн хуралдаанаар явуулах үед УИХ-ын гишүүдээс гаргасан дараах 2 зарчмын зөрүүтэй саналууд Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтад заасны дагуу дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн.

1.УИХ-ын гишүүн Шижирийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол хамрын тамхи болон усан хоолойгоор татах зориулалттай тамхины гаа болон үнэр, амтыг хориглосныг өөрчлөх.

2.УИХ-ын гишүүн Тогтмолын Мөнхсайханы гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол нь төслийн 6.7.17 буюу тамхи татах төхөөрөмжийн хайрцаг, сав, баглаа боодлын талаарх заалт дээр 2010 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр болон түүнээс хойш төрсөн Монгол Улсын иргэнд тамхи, тамхин бүтээгдэхүүн, никотин агуулсан болон никотин хүргэх зориулалттай бүтээгдэхүүнийг худалдаалахыг хориглоно. Энэ хэсэгт заасан этгээдэд тамхи, тамхин бүтээгдэхүүн, никотин агуулсан болон никотин хүргэх зориулалттай бүтээгдэхүүн худалдсан, нийлүүлсэн, үнэ төлбөргүй олгосон этгээдийн хувьд хуульд заасан хариуцлага хүлээлгэх тухай санал байх тул ажлын хэсгийн хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэн, Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасны дагуу дахин санал хураалгах шаардлагатай гэж үзлээ.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

П.Ганзориг: Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. С.Болормаа Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын суурин төлөөлөгчийн газрын Халдварт бус өвчний урьдчилан сэргийлэлт, хяналтын асуудал хариуцсан мэргэжилтэн, босоод танилцуулаад яваарай. Б.Батзориг ЦЕГ-ын Хуулийн хэлтсийн дарга байна уу, Батзориг байсан уу? Энэ дээр зөвлөчихсөн юм байх юм. Чимгэрэл Гаалийн ерөнхий газрын Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч,

Ж.Төрболд Сангийн яамны Татварын бодлогын мэргэжилтэн, Д.Долгорсүрэн Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын мэргэжилтэн, Р.Мягмаржав Татварын ерөнхий газар, Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга, Б.Отгонбаяр Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын татварын улсын байцаагч. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцууллаа.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Лутаагийн Энхнасан гишүүнээр тасаллаа. Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууя. Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүнийг оруулъя.

А.Ариунзаяа: Тамхины тухай хууль бид уг нь маш их хэлэлцүүлгүүдийг зохион байгуулаад, маш удаан, юу гэдэг юм, нэхэн шаардаад, маш их хэл амтай гарч байгаа хууль л даа. Тэгээд зарим гишүүд нь их судалгаа муутай, муу боловсруулсан, эсвэл энийг анхаарах ёстой, энэ тэр гээд л маш олон ийм хардлага сэрдлэгтэй, их хэцүү хууль явж байгаа. Тэгээд өнгөрсөн чуулганаар гишүүдийн гаргасан зарчмын зөрүүтэй санал дэмжигдээд, бүр хүнд нөхцөл байдалд оруулчихлаа энэ хуулийг. Тэгээд миний хүсэлт яах вэ энийг ч гэсэн ажлын хэсэг өөрөө харсан юм байна, тэгээд зарчмын зөрүүтэй санал дахиад гаргаж байгаа юм байна. Дэгийн тухай хуулийнхаа энэ чинь 6-н хэддүгээр, 42.2.3 байна уу? Энэ нэгдсэн хуралдаан дээр дэмжигдсэн саналаар манай Байнгын хороо 2/3-аар эргэж энэ асуудлыг харах, дахин санал хураах ийм хэрэгцээтэй гэж.

Нэг нь юу юм бэ гэхээр, Мөнхсайхан гишүүний гаргасан санал 2010 оны 1 дүгээр сарын 1-нээс хойш төрсөн хүмүүст тамхи, тамхин бүтээгдэхүүн, бүх төрлийн тамхи, тамхин бүтээгдэхүүнийг борлуулахгүй байх. Тэгээд бид яг одоо 2010 оны хүүхдээр төсөөлөөд байна. Гэтэл бид тухайн хүмүүсийг насан туршид нь буюу 25 настай, 30 настай, 40 настай, 50 настай хөгшин өвгөн болсон ч гэсэн тамхи худалдаж авах эрхгүй байх ийм асуудлыг батлах гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр бүх төрлийн тамхи гэдэг чинь юу юм бэ гэхээр нөгөө хамрын тамхи ч гэсэн орно шүү дээ. Хөөрөг зөрүүлэх эрхгүй хүртэл болгох гэж байгаа байхгүй юу бид чинь. Тэгэхээр энэ асуудлыг эргэж хараач, энэ ёстой утгагүй асуудал гэдгийг нэг хэлэх гэсэн юм.

2 дахь нь болохоор, нөгөө эргээд хөөрөг рүүгээ ормоор байна. Тамхи, тамхин бүтээгдэхүүн мөн, надаас хэвлэлийнхэн асуугаад л, дайраад л, элдэв янз болоод байсан, би хэлж байсан шүү дээ. Тамхи, тамхин бүтээгдэхүүнд энэ орно, угаасаа тамхи, тамхин бүтээгдэхүүн гэж байгаа бол хамрын тамхи ч гэсэн тамхин бүтээгдэхүүн мөн байхгүй юу. Тэгээд Шижир гишүүний гааг, амт, үнэр дээр нь нэмээд гааг хориглоно гэдэг дотор нөгөө хамрын тамхи орчихсон байгаа байхгүй юу. Тэгээд ийм байдлаар хэтэрхий нялзаагаад, Шижир гишүүнд төрсөн өдрийн бэлэг барьж байна гэж Шижир гишүүний саналыг нь дэмжээд ингээд явчихлаар энэ хууль маань бүхэлдээ маш том эрсдэлд орчихлоо. Ийм учраас 2/3-р энэ 2 заалтыг эргэж харж, дахин найруулах энэ саналыг дэмжиж, энэ 2 асуудлыг бид шийдвэрлэхгүй бол бараг Үндсэн хууль зөрчсөнд орох гээд байна.

П.Ганзориг: Ариунзаяа гишүүн санал хэллээ. Асуулт байсан уу? Ажлын хэсгийн ахлагч Чинбүрэн гишүүн хариулъя.

Ж.Чинбүрэн: Байнгын хорооны эрхэм гишүүддээ нэг зүйл анхааруулъя. Бид мэдээж тамхигүй generation буюу тамхигүй залуучууд, орчин үеийн иргэдээ

тамхигүй болгоё гэдэг сайхан санаачилга үнэхээр гайхалтай. Тэгэхдээ энэ анх удаа Монгол Улс ингэж санал гаргаж байгаа зүйл биш, дэлхийд байгаа би жишээнүүдийг хэлье. Жишээлбэл, Англи улс 2009 оны 1 дүгээр сарын 1-нээс хойш төрсөн бүх хүүхдүүдэд зөвхөн утаат тамхи хэрэглэхийг хориглосон заалттай, түүнээс вэйпийг хориглоогүй. Вэйп, никотин, патч энэ тэрийг 18 нас хүртэл хэрэглэхийг нь хатуу хориглосон зохицуулалтууд орсон. Шинэ Зеланд 2022 онд энийг баталсан анх. Шинэ Зеланд бүр хамгийн анх баталсан улс нь, тэгээд 24 оны Засгийн газар нь энэ хуулиа буцаагаад хүчингүй болгочихсон. Тийм учраас бид энэ дээр Байнгын хорооны гишүүддээ зориуд хэлээд, бид хяналтын тогтолцоогоо сайжруулах гэж зорьж байгаад энэ хуулиа бүр цаашаа явахгүй болгочих вий, үндсэн гол зорилгоосоо хазайчих вий. Тийм учраас би Ариунзаяа гишүүний энэ зарчмын зөрүүтэй санал гарч байгаад дэмжиж, Байнгын хорооны гишүүд минь дэмжиж оролцоосой гэж та бүхэнд уриалж байна.

П.Ганзориг: Лутаагийн Энхнасан гишүүн.

Л.Энхнасан: Мөнхсайханы энэ саналыг ер нь зарчмын хувьд цаашид хэрэгжүүлбэл дэмжиж байгаа. Тэгэхдээ яг одоогоор Үндсэн хуулиа зөрчих магадлалтай. Тэгээд Зөрчлийн тухай хуульд ямар нэгэн нэмэлт, өөрчлөлт оруулж байж л энэ хэрэгжих боломжтой учраас энийг ажлын хэсэг дээр ч гэсэн хасъя гэсэн санал гаргасныг дэмжиж байгаа. Импортынхоо юмаа асууж болох уу, эсвэл дараачийнхаа юу, асуух уу?

Импортын, дараачийн энэ санал дээр импортын барааны гаалийн татвар, энэ дээр нэг асуулт байна. Ер нь хуулийн энэ үндсэн зорилгыг бид бүгдээрээ дэмжиж байгаа шүү дээ. Ер нь өсвөр насны хүүхдүүдийг тамхинаас гаргах, тэгээд тамхины татварыг нэмэгдүүлэх гэдгийг зарчмын хувьд энэ гишүүд бүгдээрээ дэмжиж байгаа. Харин нөгөө хэрэгжилтийн явцад Монгол Улсын олон улсын өмнө хүлээсэн энэ үүрэгтэй зөрчил үүсэх нь үү гэж бодож байгаа учраас тодруулмаар байна. Гадаад хэргийн яамнаас албан ёсны бичиг ирсэн байна л даа, Ж.Чинбүрэн даргын нэр дээр. Бид ажлын хэсэг дээрээ ч гэсэн нэхэж байгаад энэ 6 дугаар сарын 29-нд тоот ирж. Тэгээд Гадаад хэргийн яамны албан бичигт болохоор "SH 20 22-н 24.04 ангиллын бүтээгдэхүүнд импортын гаалийн татварыг 30 хувь болгон нэмэгдүүлэх нь Дэлхийн худалдааны байгууллагад бүртгүүлсэн тарифын дээд амлалтыг зөрчих ийм эрсдэлтэй гэж дурдсан байна. Тэгээд бид нөгөө сая 24.04-ийг хасчхаж байгаа шүү дээ. Тэгээд Засгийн газарт үүрэг болгочхож байгаа.

Гэтэл энэ саяын онцгой, энэ засгаас орж ирж байгаа энэ онцгой байдлын татвар дээр 30 болон 5 хувь гэж би ойлголоо, зөв ойлгож байна уу? Хэрвээ Засгийн газар энэ өөрийнхөө тогтоолоор ингээд 24-н, сая бол юугаар орсон л доо УИХ-аар, 24.04 ангиллын бүрэлдэхүүнд 30 хувийн импортын тариф тогтоох нь зайлшгүй шаардлагатай гээд үзэж байгаа бол Монгол Улсын ДХБ-ын өмнө хүлээсэн энэ тарифын амлалтыг хэрхэн өөрчлөхөөр төлөвлөж байгаа вэ? Энийг өөрчлөхгүй болохгүй болчхож. Яагаад гэвэл ГАТТ (GATT) 1994 оны 28 дугаар зүйлийн дагуу тарифын амлалтад өөрчлөлт оруулах хэлэлцээ эхлүүлэх шаардлагатай болж байна шүү дээ. Хэрвээ, тэгээд энийг төлөвлөх үү? Хэрвээ хэлэлцээр хийгээд, энийгээ өөрчилье гэвэл ямар хугацаанд хэрэгжүүлэх юм бэ энэ талаар Гадаад харилцааны яамнаас асууж байна?

П.Ганзориг: Эхлээд ажлын хэсгийн ахлагч хариулчих, тэгээд дээр нь Гадаад хэргийн яамнаас нэмээд гүйцээгээд хариулчихаарай. Чинбүрэн гишүүний микрофоныг нээе.

Ж.Чинбүрэн: Энхнасан гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Монгол Улс ДХБ-ын тарифын энэ гэрээнд, олон улсын гэрээнд нэгдсэн, нэгдсэн учраас бид энэ тарифын дагуу татварыг тогтоох шаардлагатай болж байгаа. Тэгэхдээ энэ зөвхөн импортын татвар ярьж байгаа шүү, гаалийн татвар гэж ойлгож болно. Тэгэхлээр гаалийн татвар бид Евразитай гэрээ байгуулсантай холбоотой 7 сарын 22-ноос хэрэгжих энэ онцгой албан татварын саяын орж ирдэг Засгийн газраас өргөн барьсан онцгой албан татвар бол дандаа утаат тамхитай холбоотой ийм заалт орж ирж байгаа. Тийм учраас энэ бидний энэ хуулийн төсөлтэй нэг их харшилдах зүйл байхгүй. Харин ГХЯ-наас Батцэцэг сайдын нэр дээр ирсэн энэ албан бичиг дотор татварын зөрүүтэй тогтоох, би бүр яг уншаад өгье. Монгол Улс бүх тарифын мөрөө ДХБ-д 100 хувь баталгаажуулсан тул Монгол Улсын тарифын амлалтын жагсаалтыг БТКУС-н HS2 2022 ангилалд шилжүүлэхдээ өмнө нь тухайн бүтээгдэхүүнд үйлчилж байсан тарифын амлалтыг шинэ ангилалд босгон хөврүүлсэн тул тус ангиллын 24.04 дүгээр зүйл болон түүнд хамаарах тарифын мөрүүд, тарифын амлалтын жагсаалт тодорхой тусгачихсан ба бүтээгдэхүүний төрлөөс хамааран 6.5 хувь болон 20 хувийн тарифын дээд хэмжээ bound rate-тэй байна гэсэн ийм албан тоот ирсэн.

Тийм учраас бид энэ ажлын хэсгээрээ ярилцаад, төслөө өгөхдөө Засгийн газарт үүргийг нь өгчихье, тэгээд Засгийн газар энэ импортын тарифаа, ялангуяа энэ хууль, Тамхины хяналтын тухай хууль батлагдсантай холбоотой хэрэгжиж эхлэхээс өмнө энэ зохицуулалтаа цэгцэлж, олон улсын худалдааны байгууллагатай хийсэн гэрээнийхээ дагуу зохицуулаарай гэдэг үүргийг тогтоолоороо өгч байгаа.

П.Ганзориг: Гадаад харилцааны яамнаас төлөөлөл байгаа билүү? Нэмэлтээр хариулах хүн байхгүй, танилцуулчихсан юм байна. Энхнасан гишүүн тодруулъя.

Л.Энхнасан: Тэгэхлээр би зөв ойлгож байна уу? Нөгөө сая онцгой албан татвар орчхож байна шүү дээ, тэр чинь 30, 5 гээд 2 юм орчхож байна шүү дээ. Тэгэхлээр чинь 30 хувь нь угийн ГАТТ-ын хэлэлцээрийг зөрчиж байгаа болж байна шүү дээ. Тэгэхлээр ГАТТ-ын хэлэлцээрийг бид дахиж шинэчлэх шаардлага гарч байна шүү дээ, тэгээд энийг Гадаад хэргийн яам өөрөө ингээд төлж байгаа юм уу? Яагаад гэвэл өмнө нь энэ асуудал орж ирэхэд Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дээр Сангийн яам болон Гадаад хэргийн яам 2 өөр санал хэлж байсан шүү дээ, энэ санал нь нэгдсэн юм уу?

П.Ганзориг: Ажлын хэсгийн ахлагч Чинбүрэн гишүүн хариулъя.

Ж.Чинбүрэн: ДХБ-ын энэ хэлэлцээрт зөвхөн гаалийн татварын тухай, онцгой албан татвар бол Монгол Улсын өөрийн дотоодын асуудал учраас энэ зөрчигдөхгүй. Тэгэхлээр бид нөгөө гаалийн татварыг тэглэчихсэн учраас онцгой албан татвар дээр нэмэгдэж байгаа, онцгой албан татвар дээр нэмэгдэхлээр ДХБ-ын энэ хэлэлцээрийг зөрчиж байгаа зүйл байхгүй. Яагаад гэхлээр бид импортын татварыг тэглэчихсэн, тэр тэглэснээ онцгой албан татвар дээр тавьчихаж байгаа юм. Онцгой албан татвар энэ гадаад худалдааны хэлэлцээрт хамаарахгүй юм байна лээ.

П.Ганзориг: Дахиад тодруулах уу? Энхнасан гишүүн тодруулъя.

Л.Энхнасан: Тэгвэл ер нь Их Хуралд энэ нөгөө 24.04-ийг яг мөрдөхөд тарифын энэ хүснэгтийг зүгээр ер нь өгч болох уу? Энэ ерөөсөө ойлгомжгүй байгаа болохоор л бид ажлын хэсэг дээрээ ч энийгээ нэхээд. Сая онцгой албан татвар батлагдчихлаа шүү дээ. Тэгээд энэ импорт нь 20, 10, 5-аар явчхаж байна. Яг тэгээд аль бүтээгдэхүүн дээр, үгүй ээ, онцгой нэмэгдчихэж байгаа шүү дээ. Тийм. Тэгэнгүүт энэ олон онцгой, тэгээд гаалийн татвар энэ тэр нь яг бүтээгдэхүүн дээр яг хэд хэд очиж байгаа юм бэ гэдгийг зүгээр бид мэдмээр байна шүү дээ. Ажлын хэсэг дээр ч гэсэн энэ хүснэгтийг асуугаад байсан. Энэ Их Хуралд орохоос өмнө, чуулганд орохоос өмнө Их Хуралд танилцуулаад энэ мэдээллээ өгмөөр байна.

П.Ганзориг: Ажлын хэсгийн ахлагч хариулах уу? Ер нь ажлын хэсэг дээрээ энэ асуудлуудаа их сайн яриад мэдээллээ гол нь өгөөд ингээд тодорхой болгож ирж оруулахгүй бол Байнгын хороо, чуулган дээр ажлын хэсэг дээр мэдээлэл дутмаг байснаас болж асуулт хариулт, үл ойлголцол их явж байна шүү. Ажлын хэсгийн ахлагч Чинбүрэн гишүүн хариулъя.

Ж.Чинбүрэн: Бид өчигдөр ажлын хэсэг дээрээ нэлээдгүй яриад энэ ялангуяа энэ янжуур, вэйп, халаадаг тамхи, аманд уусдаг тамхи гэсэн ийм 4 төрлөөр зүгээр зах зээл дээр байгаа үнийг дундажлаад, тэгээд онцгой албан татвар, гаалийн албан татвар, НӨАТ нэмэгдэхэд 2025 онд байсан дүн 2027, 2031 онд яаж өөрчлөгдөх юм бэ гэдгийг тооцооллоо гаргаж үзүүл гэсэн. Үүний дагуу манай Сангийн яамнаас энэ тооцооллыг бидэнд илгээсэн. Би энийг бүр зориуд уншиж танилцуулъя. 20 ширхэгтэй янжуур гаалийн үнэ 1391 төгрөг, онцгой албан татвар одоо байгааг нь ярьж байгаа шүү, 836 төгрөг, гаалийн албан татвар 454 төгрөг, НӨАТ 412 төгрөг, ингээд 2025 онд нийтдээ 4500 төгрөг байгаа юм. Ингээд 2027 онд 7000 төгрөг болно, 2031 онд 16300 төгрөг буюу 3.6.../минут дуусав/

П.Ганзориг: Гүйцээгээд хариулъя.

Ж.Чинбүрэн: Нэг ёсондоо 2025 онд янжуур тамхинд 4500 төгрөг байсан бол 2031 онд 16300 төгрөг буюу 3.6 дахин нэмэгдэж байна. Вэйп 2025 онд түрүүний хэлсэн татваруудыг нэмээд 30 мянган төгрөг байсан бол 2027 онд 46 мянган төгрөг, 2031 он гэхэд 78 мянган төгрөг болохоор байна, энэ нь 2.6 дахин үнэ нэмэгдэхээр. Халаадаг тамхи 2025 онд одоогоор 20 мянган төгрөг байгаа бол 2027 онд 28600 төгрөг, 2031 онд 38900 төгрөг буюу нийт нэмэгдэж байгаа үнэ 1.9 дахин нэмэгдэж байна. Аманд уусдаг тамхийг 18500 төгрөг 2025 онд байгаа бол 2027 онд 25 мянга болох нь байна, 2031 онд 33500 төгрөг буюу 1.8 дахин нэмэгдэхээр байна. Ингэснээрээ дахиад хэлбэл янжуур 3.6 дахин нэмэгдэнэ, халаадаг тамхи.../минут дуусав/

П.Ганзориг: Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн асуултаа асууя.

М.Нарантуяа-Нара: Өдрийн мэнд хүргэе. Ер нь энэ Тамхины хяналтын тухай хуулийн төслийг заавал хаврын чуулганд багтааж эцэслэн батлахгүй бол болохгүй гэсэн зүйл байгаа юу 1 дүгээр асуудал?

2 дүгээр асуудал, ингээд Тамхины хяналтын тухай хуулийн одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Тамхины хяналтын хуулиар хүүхэд татахгүй байх буюу

сургуулийн орчинд тамхи худалдаалахгүй байх 6.7.14 дүгээр зүйл заалтын хэрэгжилт одоо ерөөсөө байхгүй байгаа учраас бид энэ хуулийг батлах гээд, хүүхдүүдээ хамгаалах гээд байна, тийм үү? Гэтэл энэ хууль батлагдсанаар бид одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийг мөрдөж үр дүнд хүргэж чадахгүй байгаа тухай цагдаагийн байгууллагын маш олон судалгаа мэдээллээр батлагдаж байгаа. Гэтэл бид энийгээ мөрдөж чадахгүй, сургуулийн орчны 500 метрт энэ тамхи худалдаалахыг хянаж чадахгүй, ердөө иймхэн зүйлийг хянаж чадахгүй байж одоо бид энэ хуулийг баталснаараа эргээд хүүхдүүдийг яаж үнэр, амтгүй, гааны амт, үнэр байхгүй ч гэсэн бусад төрлийн тэр янжуур болон бидний худалдаалахыг зөвшөөрч байгаа татварыг нь нэмэгдүүлээгүй байгаа үнэр, амтыг нь хориогүй байгаа тэр бүтээгдэхүүнийг татахгүй гэсэн баталгааг бид ямар механизмаар энд хангах гэж байгаа вэ 2 дугаар асуудал?

3 дугаар асуудал, Ариунзаяа гишүүн сая буруу ярьж байна. Шижир гишүүний төрсөн өдөр нь болоод УИХ-ын гишүүд төрсөн өдрийн бэлэг болгоод саналыг нь дэмжихсэн юм биш. Тамхины үнэр, амтыг нь хориглож байгаа бол гааны амтыг нь ч гэсэн хоригло гэсэн. Тийм учраас УИХ-ын гишүүд тийм юм байна, үнэр, амтыг нь хорьж байгаа бол гааг ч гэсэн хорих нь зүйтэй юм байна гээд санал өгсөн болохоос биш, саналыг нь дэмжсэн болохоос биш төрсөн өдрийн бэлэг гэж саналыг нь дэмжээгүй. Энийг бүр ноцтойгоор хэлье.

2 дугаарт, энэ Тамхины хяналтын тухай хууль анхнаасаа change esse тамхины лоббины юм шиг маш тод, товч тодорхой харагдаж байсан, ГЕГ-ын лабораторийн шинжээч хүртэл брэндийнх нь нэрийг хэлж байгаад бусад тамхинаас ямар бага хор хөнөөлтэй юм гэдэг зүйлийг хүртэл ярьснаараа ингэж бараг нотлогдох болов уу гэж би хувьдаа хардаж байна. Хэрвээ гааны амтыг тавьж өглөө гээд Шижир гишүүний саналыг унагаагаад, гааны амтыг буцаагаад тавьж өгье гэвэл энэ тэр чигээрээ гаагаар change esse далимдуулаад тамхины борлуулалтыг тэр чигээр нь тавьж өгөөд, эсрэгээрээ вэйп болон үүнтэй өрсөлдөхүйц бусад төрлийн зах зээлийг нь бүрэн хуулиар хамгаалж хааж өгч байна гэж хардахад хүргэж байна.

Дээрээс нь энэ чинь өчнөөн 300 тэрбумын татварын, татварт 300 тэрбумын орлого оруулдаг ийм бүтээгдэхүүнүүдийг бид ингээд татварын бодлогоор ингээд хаачихлаа. Хэрвээ энийг гаргаад өгөх юм бол татварт, төсөв бүрдүүлдэг татварын.../минут дуусав/

П.Ганзориг: Ажлын хэсгийн ахлагч хариулах уу? Чинбүрэн гишүүн хариулъя.

Ж.Чинбүрэн: Хяналтын тогтолцоо сайжруулах зорилгоор нэлээдгүй зүйлүүд орсон, тэгэхдээ энд нөгөө 500 метр хөндөгдөөгүй. Тийм учраас бид хууль баталсантай холбоотой Засгийн газарт өгөх үүрэг тогтоол дотроо 500 метрийн хэрэгжилтийг хянах, судлах ийм чиг үүргийг өгч байгаа юм. Тэгж байж энийг ярихгүй бол тантай санал нэг байна, ялангуяа хөдөө орон нутаг, сумдад энэ тогтолцоо маань өөрөө хэрэгжиж чадахгүй, сургууль, дэлгүүрүүд, жижиглэнгийн худалдаа эрхэлдэг байгууллагуудаас хүртэл нэлээдгүй их бичиг цаас, гомдлууд ирээд л байгаа. Тэгэхлээр бид бүгдийг хөндөж, хууль санаачлагч хөндөөгүй учраас бид хөндөж чадахгүй байгаа гэдгийг нэлээд олон удаа би хэлсэн. Тэгэхлээр тэр утгаараа бид Засгийн газарт энийгээ судал, хэрэгжиж байгаа юм уу, хэрэгжихгүй байгаа юм уу энэ заалт гэдгийг үүрэг болгож өгч байгаа.

Гаа, үнэртэй холбоотой асуудал дээр бид нөгөө хамрын тамхи дээр үнэхээр яг Ариунзаяа гишүүний хэлдгээр хамрын тамхитайгаа золгож чадахгүй болчих ийм эрсдэл, гаа, үнэр байхгүй болчихоод байгаа юм. Тэгэхлээр зөвхөн хамрын тамхин дээр энэ гаа, үнэрийн асуудлыг Байнгын хорооны гишүүдээ шийдэж өгөөч гэсэн ийм хүсэлт тавьсан, зөвхөн хамрын тамхин дээр.

П.Ганзориг: Нөгөө хугацааны хувьд хаврын чуулганд багтаад зайлшгүй батлах ёстой гэсэн ямар нөхцөл байдал үүсчхээд байгаа вэ гэдэг дээр хариулт өгөх үү.

Ж.Чинбүрэн: Бид хууль хэрэгжих хугацаа маань 2027 оны 1 дүгээр сарын 1 шүү дээ. 2027 оны 1 дүгээр сарын 1, одоо бид хавар амжихгүй байлаа гэхэд намар батлахад хуулиа 2027 оны 1 дүгээр сарын 1-ндээ л батал гэдэг л ийм чиглэл өгнө.

П.Ганзориг: Нарантуяа-Нара гишүүн тодруулъя.

М.Нарантуяа-Нара: Тэгэхээр энэ хуулийг ер нь хууль санаачлагчид нь дахиад буцааж болохгүй юм уу? Яагаад гэвэл одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Тамхины хяналтын тухай хуулийн 6.7.14-ийн хэрэгжилт, үр дүнг хэмжээгүй байж яг энэ эрсдэлийг шууд ингээд, ер нь бид ажлын хэсэг дээр ч гэсэн байнга яригдаж байгаа, одоо байгаа нөхцөл байдлыг зөвхөн зах зээлийн судалгаагаар бид үнэлээд хууль батлах чинь өөрөө асар учир дутагдалтай явдал байна.

2 дугаарт, бид төсөвт 300 тэрбумын орлого оруулдаг энэ бизнесийг хуулиар хааж өгөнгүүтээ эсрэгээрээ бид хууль бус худалдаагаа яаж хянах юм, ямар механизмаар хянах юм бэ? Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийг бид ганцхан зүйл, заалтыг нь хянаж чадахгүй, тэрийгээ тэрнээсээ үндэслэж тусгаж, эрсдэлийг тооцоолж энд оруулж ирээгүйгээр явж байгаа энэ хуулийг батлах гээд чичрээд сууж байгаа нь учир дутагдалтай. Дээрээс нь бүр хүний эрхийг зөрчсөн ийм асуудал орж ирж байхад.../минут дуусав/

П.Ганзориг: Үг хэллээ. Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн асуулт асууя. Нарантуяа-Нара гишүүний асуулт. Ажлын хэсгээс хариулах юм уу, татвараас хариулах юм уу? Татварын ерөнхий газар байна уу? Татварын орлого тасалдах гээд байна 300 тэрбумаар. Индрийн микрофон дээр гараад татвараас хариулт өгчих. Ажлын хэсгийн ахлагч хариулчихъя. Чинбүрэн гишүүний микрофоныг нээе.

Ж.Чинбүрэн: Нарантуяа-Нара гишүүнээ, татвар буухтай холбоотой нэг л зүйлийг би чуулган дээр ч хэлсэн зүйлээ хэлье гэж бодож байгаа. Бид энэ татвар цуглуулах зорилготой хууль биш, илүү өсвөр үеийнхнээ тамхинд, никотинд донтуулахгүй байх л хяналтыг хийхийг зорьж байгаа юм. Дутуу зүйлүүд байгаа, би тантай санал нэг байна. Ажлын хэсэг дээр бид зөндөө ярьж байгаа, хяналтын тогтолцоогоо илүү яаж сайжруулах вэ, ярих зүйлүүд байгаа. Тэгэхлээр бид ямар ч байсан энэ хуулиа өргөн барьсан энэ хувилбарыг чадлынхаа хэрээр сайжруулаад Байнгын хороогоор оруулж байна.

П.Ганзориг: Тамхины хяналтын тухай хууль бол өнгөрсөн оны 9 дүгээр сарын 19-нд өргөн бариад ер нь ингээд 7, 8 сар үргэлжилж байгаа ийм хууль. Ажлын хэсэг нэлээн өргөн бүрэлдэхүүнтэй гарч ажилласан, тэгээд энэ дээр саналуудаа их сайн яриад явах ёстой, яриад нэгтгэгдээд орж ирж байна гэж бодож байгаа.

2-т, Нарантуяа-Нара гишүүн энэ хуулийг хууль санаачлагч буцааж болох уу гээд тэгж байна, шууд буцаадаг хууль зүйн зохицуулалт байхгүй. УИХ-ын гишүүд эцэслэн батлах дээр батлахгүй бол буцдаг, эсвэл хууль санаачлагч өөрөө аль ч түвшнээс нь, хэлэлцүүлгийн шатнаас буцаагаад татаж болдог. Тэгэхээр энэ өөрөөр хэлбэл УИХ-ын бүрэн эрхийн асуудал, тийм болохоор энд Байнгын хороон дээр энэ асуудлыг яриад ямар ч шийдэл, шийдвэр гарахгүй. Байнгын хороо, ажлын хэсгийн шийдэх асуудал огтоос биш шүү гэдгийг тодотгож хэлье. Нарантуяа-Нара гишүүн тодруулъя.

М.Нарантуяа-Нара: Ер нь хууль санаачлагч төдийгүй бид ч гэсэн хүүхдийг тамхи татуулахгүй байя гэж байгаа шүү дээ. Гэхдээ бид одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийг хэрэгжүүлж үр дүнг нь хэмжиж чадахгүй байгаа байж, дахиад араас нь ийм юм оруулж ирээд юугаар бид тэр хуулиа хамгаалах юм бэ, хэрэгжүүлэх юм бэ, хянах юм бэ гэдэг асуултыг л тавихад хариулж чадахгүй байгаад байгаа. Ажлын хэсгийн ажил дээр ч гэсэн зуун задгайгаараа явж байгаа ажлыг яг одоо ингээд урагшаа нэг алхъя, ямар ч байсан баталъя гээд байгаа чинь буруу. Яагаад гэвэл явцын дунд сайжруулъя ч гэж байх шиг. Хууль батлагдаад л бол тас, тэр хэрэгжих өдрөөс авхуулаад л тас шүү дээ. Тийм учраас дунд нь сайжруулах ямар ч боломж байхгүй. Харин бид анхаарах, эрсдэлийг тодруулах, урьдчилан сэргийлэх, хамгаалах, хянах тэр механизмаа энэ хууль дээрээ өөрөө шигтгэж өгч байж бүх юм нь тодорхой хуулийг батлах ёстой болохоос биш ямар ч байсан нэг урагшилъя, нэг алхъя, нэг алхам урагшилъя гээд урдах асуудлууд нь, гишгэх цэгүүд нь эмзэг эгзэгтэй байгаа цагт нүдээ аньж байгаад гишгэж.../минут дуусав/

П.Ганзориг: Үг хэллээ. Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн асуулт асууя.

П.Наранбаяр: Баярлалаа. Энэ Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах энэ төслийг нэлээн иргэд их сонирхож байна. Ялангуяа энэ БЗД-ийнхээ иргэдтэй уулзаад явж байхад 15 дугаар хорооны Засаг дарга Солонго гэдэг эмэгтэй хэлж байсан, ер нь энэ вэйпийг татуулдаг ингэсэн нөгөө ирээдүй үеэ ийм тамхинд 1 дүгээрт донтуулах эхний ийм алхмуудыг хийчхээд байна, 2 дугаарт хаа сайгүй татаж байна, 3 дугаарт ирээдүйд хар тамхи татахыг ч үгүйсгэхгүй гэж маш их ийм сэтгэл зовнисон байдлаар илэрхийлж байсан. Тэгэхээр нэг ийм дуу хоолой байгааг энд хэлье.

Миний асуух гээд байгаа зүйл, нөгөө талдаа бид энэ, миний бие вэйпийг тамхинд тооцож онцгой албан татвар тогтоох энэ тэр бүгдийг маш дэмжиж байгаа. Зүгээр нөгөө талдаа энэ Тамхины хяналтын тухай хууль гарснаас хойш ер нь амьдралд хэрэгжиж өгөхгүй байгаа, эсвэл амьдралд хэрэгжүүлэхэд эрх мэдэлтэнд илүү их боломж олгоод, тэгээд жижиглэн худалдаа эрхэлж байгаа жирийн иргэддээ их хатуу буулт болоод байгаа ийм нэг заалт байдаг, тэр нь 500 метр. Энэ 500 метр дотор зарахгүй гэсэн энэ заалтыг хэрэгжүүлэх явцад элдэв бэрхшээл гардаг, тэндээсээ болоод АТГ-т хүртэл шалгагдсан ийм тохиолдол байна шүү дээ. Жишээлбэл, Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг дарга Жавхаатөгс гэдэг хүнийг 5 жилээр ингээд янз янзын нөхцөл байдлаар бусдад давуу эрх олгосон гэх мэтээр. Гэтэл энийг нь сонсоод байхаар бодит амьдрал дээр хэрэгжих боломжгүй учраас нөгөө жижиглэн худалдаачид чинь ерөөсөө шууд лангуун доороосоо нууцаар зардаг гэсэн ийм л нөхцөл байдал руу оруулчихсан.

Тэгэхээр энэ зүйл, заалт хөндөгдөөгүй учраас оруулахгүй гэдгийг ажлын хэсэг ч хэлж байсан, санаачлагч гол гишүүд маань ч ярьж байсан. Нэгэнт хөндөгдөхгүй байгаа энэ нөхцөлд ямар ч байсан бид Засгийн газарт чиглэл өгөх нь зүйтэй, энэ амьдралд хэрэгжээд байна уу, үнэхээр хэрэгжихгүй ингээд хүмүүс хохироогоод олон талаас энэ тамхины далд наймааг дэмжих ийм хэлбэр лүү яваад байна уу. Ийм тохиолдолд энийгээ өөрчилж оруулж ир, энэ заалтыг эргэж хар гэсэн ийм чиглэлийг энэ УИХ-ын энэ хуулиар дагаж гарах Засгийн газарт чиглэл өгөх тогтоолд оруулахаар миний бие саналаа ажлын хэсгийн ахлагчид өгсөн. Түрүүн ингээд сонсож байхад орж байгаа гэсэн ийм юм хэлж байна, энэ сайн хэрэг. Тэгэхдээ ямар байдлаар орж байгааг тодорхой хэлж өгнө үү гэж хүсэж байна.

2 дугаарт, ер нь энэ хуулийг бид гаргах нь зүйтэй, гэхдээ энэ хуулийг гаргахдаа олон талаас нь бодож, олон дуу хоолойг сонсож ингэж гаргах нь зүйтэй шүү. Сая УИХ-аар эхний хэлэлцүүлэг нь яваад, хэлэлцэх эсэх нь хэлэлцэгдээд ингээд гарлаа. Энэ онцгой албан татвар дээр тамхины онцгой албан татварыг Евразийн хэлэлцээрт хамрагдаж байгаа улс орнуудаас орж ирж байгаа тохиолдолд орохоор болж байна, энэ зүйтэй, энэ дээр хариулт өгөөч гэж хүсэж байна?

П.Ганзориг: Наранбаяр гишүүн чухал асуудал хөндлөө. Тэр зайтай холбоотой асуудлаар энэ хууль батлахад дагаж гарах УИХ-ын тогтоол дээр хяналт-шинжилгээ хийх, дүгнэлт хийх асуудал нь орж байгаа. Тэгээд ажлын хэсэг шаардлагатай бол нэмээд хариулчих. Ажлын хэсгийн ахлагч хариулах уу, тодорхой орчихсон юм чинь. Чинбүрэн гишүүн хариулъя.

Ж.Чинбүрэн: Тэгэхлээр би танд хэлсэнчлэн Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай тогтоол дотор 6 дугаар заалт дотор Тамхины хяналтын тухай хуулийн 6.7.14 дэх заалтын хэрэгжилт нь тамхины далд худалдааг нэмэгдүүлэх нөхцөл бүрдүүлж байгаа эсэхийг судалж, шаардлагатай тохиолдолд уг заалтыг хүчингүй болгох талаар холбогдох арга хэмжээ авах гэсэн ийм тогтоолын заалт орж байгаа. Би дээр хэлж байсан, Идэрбат гишүүн ажлын хэсгийг ахлаад ажиллаж байхдаа гишүүдэд санал хэлсэн байна лээ. Энэ 500 метртэй холбоотой асуудлаар бүрэн эрхийнхээ хүрээнд УИХ-ын гишүүд хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулахаар энэ заалтыг судлаад, яагаад, оруулж ирж болох бүрэн нээлттэй байгаа гэж хэлж байсан. Тэгэхлээр бид энэ тогтоол дотроо 6 дугаар заалт болгож оруулж ирсэн.

П.Ганзориг: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалтууд явагдахад ажлын хэсгээс гарсан гүйцээн боловсруулах чиглэлтэй холбоотой болон ажлын хэсгээс мөн 2/3-оор санал хураалгахаар оруулж ирсэн учраас гишүүд энэ Байнгын хорооныхоо хуралдааны танхимд хүрэлцэж ирэхийг хүсье. Нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг гүйцээн боловсруулж, хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар УИХ-ын даргаас чиглэл өгсөн бөгөөд УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 болон 42.2.3 дахь заалтад заасны дагуу санал хураалгах зарчмын зөрүүтэй 2 саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Ажлын хэсгээс бэлтгэсэн саналын томьёоллыг уншиж танилцуулъя. Үүн дээр ердийн олонх, ердийн олонх, дараагийнхаа санал, 2 санал хураалт дээр харин гишүүдээ оруулж ирэх хэрэгтэй.

Ирцэд орсон боловч яг танхимд орж ирээгүй Цэндийн Баатархүү, Отгоншарын Батнайрамдал, Даваасамбуугийн Ганмаа, Тогтмолын Мөнхсайхан, Мягмардашийн Сарнай, Банзрагчийн Түвшин, Сүхбаатарын Эрдэнэбат нарын гишүүд Байнгын хорооныхоо хуралд орж ирж, энэ санал хураалтдаа оролцохыг хүсье. Ингээд саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

1.Төслийн 1 дэх заалтыг бүхэлд нь доор дурдсанаар өөрчлөн найруулах:

"1.Импортын барааны гаалийн албан татварын хувь хэмжээг батлах тухай Монгол Улсын Их Хурлын 1999 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 27 дугаар тогтоолын хавсралтад доор дурдсан агуулгатай дараах 85.43, 96.14 дүгээр зүйл, үндэсний код нэмсүгэй:

1/85 дугаар бүлгийн 85.43 дугаар зүйл. 85.43.энэ бүлгийн бусад газар заагдаагүй, ганцаарчилсан зориулалтын цахилгаан машин болон аппарат, хувь хэмжээ дээр нь 5 (би энэ хүснэгтэн мэдээллийг мөрийнх нь дагуу уншиж байна) 85.43 дугаар бүлгийн дэд бүлэг, 85.43.40.00, 2 дугаар мөр Электрон янжуур болон түүнтэй төстэй цахилгаанаар ажилладаг ууршуулж татах хэрэгсэл, тоо хэмжээ нь 20. 3 дахь мөр 85.43.90.00. Эд анги электрон тамхи болон түүнтэй төстэй цахилгаанаар ажилладаг ууршуулж татах төхөөрөмжийн гэдэг дээр тоо хэмжээ нь 20, бусад гэдэг дээр 5. Санал хураалт. Хоёуланг нь унших уу? Энэ 2 дахь мөр нь цуг яваа юм биш үү, би тусдаа санал гэж харсан. 2.96 дугаар бүлгийн 96.14 дүгээр зүйл, 9614.00.00. Тамхины гаанс (гаансны толгой орно) болон сигар, янжуур тамхины соруул, тэдгээрийн эд анги, тоо хэмжээ 20. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн орсноос 13 гишүүн дэмжиж, санал 61.9 хувиар дэмжигдлээ.

2 дахь санал хураалт. Төслийн 2 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн орсноос 13 гишүүн дэмжиж, санал 61.9 хувиар дэмжигдлээ.

Гишүүд санал хураалтдаа бэлтгээд орсон байна. Ингээд нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэгт буюу 2026 оны 6 дугаар сарын 25-ны өдөр гишүүдээс гарсан, Шижир гишүүн болон Мөнхсайхан гишүүнээс гарсан саналууд нэгдсэн чуулганы хуралдаанаар дэмжигдсэн саналаар, мөн Ариунзаяа гишүүн дахин санал хураалгах ийм горимын санал гаргасан. Тэгээд энэ саналаар хураалгахын тулд Байнгын хорооны гишүүдийн 2/3 нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд энэ саналын томъёоллоор санал хураалгана, тус тусад нь хураана. Тэгэхээр би энэ 2 саналыг тус тусад нь саналын томъёоллоор та бүхэнд танилцуулъя.

1, Аюушийн Ариунзаяа гишүүний гаргасан төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6 дугаар зүйлийн 6.7.16 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах. Энэ тухайлбал Шижир гишүүний гаргасан, тэгээд чуулганаар дэмжигдсэн саналаар дахиж санал хураалгах гэж байгаа гэсэн үг: "6.7.16.тамхи татах төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, татах төхөөрөмжийн эд ангид тамхинаас өөр төрлийн үнэр, амт оруулагч бодис нэмсэн байх;" гэсэн саналаар дахин санал хураалгах шаардлагатай гэсэн саналыг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулъя. Ингээд энийг, санал хураалт гишүүдээ, санал хураалт явуулъя. Санал хураалтад нийт 21 гишүүн орсноос 15 гишүүн дэмжиж, 71.4 хувь нь дэмжсэн тул уг санал дэмжигдлээ.

Байнгын хорооны гишүүдийн 2/3-оос дээших нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн тул Ариунзаяа гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6 дугаар зүйлийн 6.7.16 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

"6.7.16.хамрын тамхи, усан хоолойгоор татах зориулалттай тамхинаас бусад тамхи татах төхөөрөмж, түүний эд ангид тамхинаас өөр төрлийн үнэр, амт оруулах бодис, бэлдмэл нэмсэн байх" Санал гаргасан Аюушийн Ариунзаяа. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн оролцсоноос 15 гишүүн дэмжиж, санал 71.4 хувиар дэмжигдлээ.

2 дахь зарчмын зөрүүтэй санал хураалгах гэж байна шүү гишүүдээ. Энэ ажлын хэсэг болоод гаргасан гишүүдийн үндэслэл Үндсэн хуулийн хүний эрх зөрчигдсөн чухал асуудал байгаа болохоор дахиж хураалгахгүй бол болохгүй. Тийм болохоор гишүүд энэ асуудал дээр анхааралтай, хариуцлагатай хандахыг хүсье. Мөн нэгдсэн чуулганы хуралдааны анхны хэлэлцүүлгээр буюу 2026 оны 6 дугаар сарын 25-ны өдөр дэмжигдсэн, тэгээд Байнгын хорооны гишүүдийн 2/3 нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзэх юм бол хураалгахаар байгаа. Энэ саналыг Аюушийн Ариунзаяа гишүүний гаргасан зарчмын саналыг уншиж танилцуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6.7.17 дахь заалтад доор дурдсан агуулгатай өгүүлбэр нэмэх:

"2010 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр болон түүнээс хойш төрсөн Монгол Улсын иргэнд тамхи, тамхин бүтээгдэхүүн, никотин агуулсан болон никотин хүргэх зориулалттай бүтээгдэхүүнийг худалдахыг хориглоно. Энэ хэсэгт заасан этгээдэд тамхи, тамхин бүтээгдэхүүн, никотин агуулсан болон никотин хүргэх зориулалттай бүтээгдэхүүн худалдсан, нийлүүлсэн, үнэ төлбөргүй олгосон этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ." гэсэн заалтаар дахин санал хураалгах шаардлагатай гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Байнгын хорооны гишүүдийн 2/3-оос дээших нь буюу 21 гишүүн орсноос 17 гишүүн дэмжиж, 81 хувь нь дэмжсэн тул уг асуудлаар дахин санал хураалт явуулъя. Би саналын томьёоллыг уншиж танилцуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6.7.17 дахь заалтаас доор дурдсан агуулгатай 2 өгүүлбэрийг хасах, 2 дахь өгүүлбэрийг хасах. "2010 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр болон түүнээс хойш төрсөн Монгол Улсын иргэнд тамхи, тамхин бүтээгдэхүүн, никотин агуулсан болон никотин хүргэх зориулалттай бүтээгдэхүүн худалдахыг хориглоно. Энэ хэсэгт заасан этгээдэд тамхи, тамхин бүтээгдэхүүн, никотин агуулсан болон никотин хүргэх зориулалттай бүтээгдэхүүн худалдсан, нийлүүлсэн, үнэ төлбөргүй олгосон этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ." Санал гаргасан Аюушийн Ариунзаяа гишүүн. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн орсноос 18 гишүүн дэмжиж, санал 85.7 хувиар дэмжигдлээ. Санал хураалт явагдаж дууслаа.

УИХ-ын гишүүн Номинчимэг нарын 71 гишүүнээс 2025 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай асуудлыг хэлэлцэж дууслаа.

Хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн ахлагч танилцуулах уу, ажлын хэсгийн ахлагч Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн танилцуулна.

18.19 цаг

Ер нь энэ хууль хэлэлцэж байгаа процесс 4 үе шатанд явагдаж байгаа. Бүх шатанд нь гишүүд зарчмын зөрүүтэй санал гаргах, ажлын хэсэгт гаргах бүх бололцоо нээлттэй байгаа шүү. Бүх саналуудыг би хураалгаж байгаа, ирсэн саналуудыг. Тийм болохоор өөрсдөө гишүүд саналтай байгаа тохиолдолд саналаа ажлын хэсэг болоод гишүүнийхээ хувиар гаргаад, санал хураалт явагдахаас өмнө өгөөд саналаа хураалгаад явах бүрэн боломжтой гэдгийг хэлье.

Хоёр.Асрах үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяа нарын 65 гишүүн 2026.06.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё. УИХ-ын гишүүн Д.Энхтуяа нарын 65 гишүүн 2026 оны 6 дугаар сарын 22-ны өдөр өргөн мэдүүлсэн Асрах үйлчилгээний тухай анхдагч хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх талаарх хэлэлцүүлгийг явуулъя. Хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг УИХ-ын гишүүн Д.Энхтуяа танилцуулна.

Д.Энхтуяа: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Асрах үйлчилгээний тухай анхдагч хуулийн төслийнхөө товч танилцуулгыг танилцуулъя. Асрах үйлчилгээтэй холбоотой харилцаа Нийгмийн халамжийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид хэсэгчлэн тусгагдсан боловч үйлчилгээний төрөл, хэлбэр, чанар, хүний нөөц, санхүүжилт, төрийн болон хувийн хэвшлийн оролцоо, үйлчилгээ үзүүлэгч болон үйлчилгээ авагчийн эрх, үүргийг цогцоор нь зохицуулсан бие даасан эрх зүйн орчин одоогоор бүрдээгүй байгаа юм.

Үүний улмаас асрах үйлчилгээний хүртээмж хангалтгүй, үйлчилгээний чанар харилцан адилгүй, хувийн хэвшил болон төрийн бус байгууллагын оролцоо сул, хүний нөөцийн тогтолцоо төлөвшөөгүй, санхүүжилтийн эх үүсвэр хязгаарлагдмал хэвээр байна. Мөн асрах үйлчилгээ шаардлагатай олон иргэн хэрэгцээндээ нийцсэн үйлчилгээ авч байгаа нь тэдний амьдралын чанар, эрүүл мэнд, нийгмийн оролцоонд сөргөөр нөлөөлж байна. Дэлхийн олон улс оронд хүн амын насжилт, урт хугацааны асаргааны хэрэгцээ нэмэгдэж байгаа нөхцөлд асрах үйлчилгээг нийгмийн хамгааллын бие даасан тогтолцоо болгон хөгжүүлж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын оролцоонд тулгуурласан эрх зүйн зохицуулалтыг бий болгож байна. Иймд асрах үйлчилгээний төрөл, хэлбэр, шаардлага, үйлчилгээ үзүүлэгч болон үйлчилгээ авагчийн эрх, үүрэг, санхүүжилтийн тогтолцоо, төрөөс үзүүлэх дэмжлэг, хяналт, хариуцлагын эрх зүйн үндсийг бүрдүүлэх зорилгоор Асрах үйлчилгээний тухай анхдагч хуулийн төслийг боловсрууллаа.

Асрах үйлчилгээний тухай анхдагч хуулийн төсөл нь асрах үйлчилгээний эрх зүйн үндсийг тогтоож, асрах үйлчилгээний төрөл, ангилал, хэлбэр, үйлчилгээ үзүүлэхэд тавигдах шаардлага, үйлчилгээ үзүүлэгч болон үйлчилгээ авагчийн эрх, үүрэг, талуудын хамтын ажиллагаа, хүний нөөц, сургалт, санхүүжилт, төрөөс үзүүлэх дэмжлэг, хяналт, хариуцлагатай холбогдсон харилцааг цогцоор нь

зохицуулахад чиглэсэн болно. Төсөл нь нийт 10 бүлэг, 30 зүйлээс бүрдэх бөгөөд асрах үйлчилгээний нийтлэг үндэслэл, үйлчилгээний төрөл, хэлбэр, үйлчилгээ үзүүлэгч болон үйлчилгээ авагчийн эрх, үүрэг, хүний нөөц, санхүүжилт, даатгал, төрийн дэмжлэг, хяналт, хариуцлага болон бусад холбогдох харилцааг зохицуулна.

Хуулийн төсөл нь хүн амын насжилт, хөгжлийн бэрхшээл, урт хугацааны асаргаа шаардлагатай иргэдийн өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээнд нийцсэн асрах үйлчилгээний эрх зүйн орчныг бүрдүүлэх, асрах үйлчилгээг бие даасан нийгмийн үйлчилгээ болгон хөгжүүлэх, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын оролцоонд тулгуурласан үндэсний тогтолцоог бий болгоход чиглэгдсэн. Хуулийн төсөлд асрах үйлчилгээтэй холбоотой харилцааг бие даасан хуулиар цогцоор зохицуулахаар тусгалаа. Асрах үйлчилгээний хамрах хүрээг зөвхөн ахмад настан ахиад хязгаарлахгүйгээр өдөр тутмын амьдралын үйл ажиллагааг бие даан гүйцэтгэх боломж нь хязгаарлагдсан, бусдын тусламж, дэмжлэг шаардлагатай бүх хүнд хэрэгцээнд нь тулгуурлан үйлчилгээ үзүүлэхээр тогтоолоо. Түүнчлэн асрах үйлчилгээг өдөр тутмын ахуйн асаргаа, сэргээн засах асрах үйлчилгээ, хүний эрх болон нийгмийн оролцоог дэмжих үйлчилгээ гэсэн төрөл байхаар, мөн гэрээр, байгууллагад, явуулын болон өдрийн үйлчилгээний хэлбэрээр зохион байгуулахаар зохицууллаа.

Хуулийн төсөлд асрах үйлчилгээг тусгай нөхцөл, шаардлагыг хангасан этгээд эрхлэхээр тогтоож, төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоог дэмжих эрх зүйн орчныг бүрдүүллээ. Мөн төрөөс үйлчилгээ худалдан авах, татварын болон төлбөрийн дэмжлэг үзүүлэх, сайн дурын даатгалын тогтолцоог хөгжүүлэх зэрэг олон эх үүсвэрт санхүүжилтийн механизмыг тусгалаа. Түүнчлэн хүний эрхийг дээдлэх, асруулагчийн хүсэл, сонголтыг хүндэтгэх, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах, ил тод, хариуцлагатай байх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах зэрэг асрах үйлчилгээний суурь зарчмуудыг тусгалаа.

Асрах үйлчилгээтэй холбоотой харилцааг Монгол Улсад өнөөг хүртэл бие даасан тусгайлсан хуулиар зохицуулаагүй байна. Одоогийн байдлаар энэхүү харилцааг Нийгмийн халамжийн тухай хууль болон бусад салбарын хууль тогтоомжийн хүрээнд хэсэгчлэн зохицуулж байгаа бөгөөд асрах үйлчилгээг нийгмийн халамжийн үйлчилгээний нэг бүрэлдэхүүн хэсэг байдлаар тусгасан байдаг. Монгол Улс 2012 онд Нийгмийн халамжийн тухай хуулийг баталж, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээг эрх зүйн хүрээнд зохицуулсан нь тухайн үеийн нөхцөлд чухал ахиц болсон. Уг хуулиар ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд зэрэг зорилтот бүлэгт үзүүлэх асрамжийн үйлчилгээний үндсийг тодорхойлжээ.

УИХ-ын даргын 2024 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 100 дугаар захирамжаар асрах үйлчилгээний эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр судалж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажилласан. Уг хуулийн төслийг боловсруулахдаа Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалгаа, мөн хуулийн 17 дугаар зүйлд заасан хуулийн төслийн үр нөлөөллийн үнэлгээг тус тус хийж гүйцэтгэсэн. Судалгааны хүрээнд асрах үйлчилгээний өнөөгийн эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт, тулгамдсан асуудал, олон улсын туршлага болон зохицуулалтын боломжит хувилбаруудыг

судлан шинжиллээ. Түүнчлэн тухайн төслийн үзэл баримтлалыг боловсруулж, уг төсөлтэй хамт Нийгмийн халамжийн тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Үндэсний баялгийн сангийн тухай хууль, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, Асрах үйлчилгээний тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг тус тус боловсруулсан.

Уг төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу олон нийтийн хэлэлцүүлэгт оруулж, төрийн байгууллага, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага, эрдэмтэн судлаачид болон иргэдээс санал авч хэлэлцүүллээ. Ирүүлсэн санал, зөвлөмжийг ажлын хэсэг нэг бүрчлэн судалж, үндэслэл бүхий саналуудыг тухайн хуулийн төсөлд нэмж тусгав. УИХ-ын Тамгын газрын дэргэдэх Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн 2024 онд гадаад улсын асрах үйлчилгээний эрх зүйн орчны зохицуулалтын харьцуулсан судалгаа хийсэн бөгөөд уг судалгаагаар ХБНГУ, Бүгд Найрамдах Солонгос Улс, Их Британи, Япон улсын төрөлжсөн асрамжийн үйлчилгээний зохицуулалтыг судаллаа. Судалгааны үр дүнгээс үзэхэд хүн амын насжилт нэмэгдэж байгаа улс орнууд урт хугацааны асаргааны үйлчилгээг нийгмийн хамгааллын тогтолцооны бие даасан, чухал бүрэлдэхүүн болгон хэрэгжүүлж хөгжүүлсэн байна. Ялангуяа Герман, Япон, БНСУ зэрэг орнууд нь урт хугацааны асаргааны үйлчилгээний эрх зүйн орчныг хуулиар зохицуулж, даатгал, санхүүжилт, үйлчилгээний чанар, хүний нөөц, хяналтын тогтолцоог цогцоор нь бүрдүүлсэн байна.

Уг төслийг боловсруулахдаа УИХ-ын Тамгын газрын дэргэдэх Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн хийсэн харьцуулсан судалгаа, Азийн сангийн 2024 оны асрахуйн эдийн засгийн судалгаа, Монгол Улсын ХЭҮК-ын ахмад насны эрхийн судалгаа болон бусад холбогдох эх сурвалжийг ашиглалаа. Судалгааны дүнгээс харахад Монгол Улсад асрах үйлчилгээний хэрэгцээ өсөн нэмэгдэж байгаа боловч эрх зүйн зохицуулалт, санхүүжилт, үйлчилгээний хүртээмж, хүний нөөцийн тогтолцоо хангалтгүй байна. Мөн асрахуйн хөдөлмөрийн ачаалал их өрх гэр, ялангуяа эмэгтэйчүүдэд төвлөрч байгаа нь хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн оролцоонд сөргөөр нөлөөлж байна. Азийн хөгжлийн банкны тооцооллоор өрх болон, хөдөлмөрийн зах зээл дэх жендерийн тэгш бус байдлыг бууруулж, асрахуйн эдийн засгийг хөгжүүлснээр эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоог нэмэгдүүлж, Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг дэмжих боломжтой гэж үзлээ. Иймээс асрах үйлчилгээг бие даасан эрх зүйн зохицуулалттай болгон хөгжүүлэх нь зөвхөн нийгмийн хамгааллын төдийгүй хүний хөгжил, хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн бодлоготой шууд холбоотой ач холбогдолтой гэж үзэж байна.

Уг хуулийн төсөл батлагдсанаар асрах үйлчилгээний эрх зүйн орчин анх удаа бие даасан хуулиар бүрдэж, үйлчилгээний төрөл, хэлбэр, шаардлага, хүний нөөц, санхүүжилт, хяналт шалгалт, хариуцлагын нэгдсэн тогтолцоо бий болно. Мөн асрах үйлчилгээний хүртээмж, чанар сайжирч, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд болон бусдын дэмжлэг шаардлагатай байгаа иргэнд хэрэгцээнд нь нийцсэн үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх юм. Түүнчлэн төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа хөгжих, хөгжүүлэх, асрах үйлчилгээний салбарт хөрөнгө оруулалт, шинэ үйлчилгээ, мэргэшсэн хүний нөөц бий болох үндэслэл бүрдэх юм, танилцуулж дууслаа.

П.Ганзориг: Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. А.Даваажаргал Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Д.Оросоо Монголын хуульчдын холбооны гишүүн, хуульч, судлаач, Д.Энхбат хуулийн зөвлөх, Б.Батцэцэг МУИС-ийн докторант, судлаач, Б.Төрболд хуульч, судлаач. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулж дууслаа.

Танилцуулгатай холбоотой асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Асуулт явж байгаа. Хуулийн төслийн танилцуулгатай холбоотой үг хэлэх гишүүн байна уу? Наранбаяр гишүүнээр тасаллаа, Ганбаатар гишүүнээр тасаллаа. Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн үг хэлье.

П.Наранбаяр: Энэ Асрах үйлчилгээний тухай хуулийн төслийг өргөн барьж байгаад миний бие их баяртай байна. Яагаад гэвэл энэ хуулийн төслийг харахад өнөөдөр асрах үйлчилгээг зөвхөн ахмадын асрамж гэж харж, зөвхөн нийгмийн халамжийн нэг хэсэг гэж харж ирсэн энэ өрөөсгөл ойлголтыг эвдэж эхэлж байгаад баяртай байна гэсэн үг. Мөн энэ асрах үйлчилгээ гэдэг өнөөдөр AI хиймэл оюун, дээр нь нэмээд роботууд хүний ажлыг орлож байгаа ийм үед асрах үйлчилгээг хэн ч орлож чадахгүй, хүн л хүнээ асарна. Ийм нөхцөл байдалд энд өөрөө эдийн засгийн эргэлтэд орох, мөн үйлчилгээний цоо шинэ ийм төрөл Монголд хөгжих боломжийг бий болгож байгаа ийм эрх зүйн үндэс нь гарч ирж байгаад баяртай байна гэсэн үг. Мөн silver economy silver юу гэдэг юм ахмадуудад зориулсан ахмадын эдийн засаг, мөнгөн эдийн засаг гэж өнөөдөр ялангуяа хүн амын хөгшрөлт их хүчтэй явагдаж байгаа газруудад энэ маш их анхаарал татаж байгаа зүйл. Манай улс ч гэсэн хөдөлмөрийн насны хүмүүсийн цонх үе нь удахгүй дуусаад, цаашдаа ахмадууд нэмэгдэнэ гэж ингэж тооцож байгаа шүү дээ. Тэтгэврийн хуулийг ч энэ зорилгоор шинэчилж эхэлж байгаа. Тэгэхээр энэ нөхцөлд бид ахмадуудыг, мөн зөвхөн ахмад биш ийм асрамж, үйлчилгээ, асрах үйлчилгээ хэрэгтэй хүмүүст зориулсан хууль гарч байгаад туйлын баяртай байгаа.

Тэгэхээр энэ хуулийн төсөлд, ялангуяа хувийн хэвшлийн оролцоог хангах, НӨАТ болон бусад татварын хөнгөлөлтийг үзүүлж, ийшээгээ хөрөнгө оруулалтыг татаж, НДШ болон бусад нийгэмд өөрт нь зориулсан сайн дурын даатгал, хувийн тэтгэврийн даатгал эд нар гээд эндээс нь ашиглах боломжийг маш сайн олгож өгөх нь өөрөө энэ богино хугацаанд асрахуйн салбарыг Монгол Улсад том үйлчилгээний салбар болгох боломж байна гэж харж байна. Түүний зэрэгцээ бэлтгэж байгаа боловсон хүчнээ гадаадад хамаагүй алдахгүй байхад анхаарах ёстой. Өнөөдөр сувилахуйн ухааны сургуулиудад сурсан сувилагч нарыг Солонгосчууд, Япончууд булаалдаад аваад явчхаж байна шүү дээ. Бэлтгэж байгаа нь дэлхийн түвшинд сайн бэлтгэж байгаа, манайхан муу бэлдэж байгаа юм ерөөсөө байхгүй, тэгээд л цааш нь булаагаад аваад явж байгаа. Тэгэхээрээ дэлхийн зах зээл дээр бид ийм өрсөлдөөний, глобалчлагдсан өнөөгийн нөхцөлд өрсөлдөөний зах зээл рүү ороод ирчихсэн гэдгийг ойлгож, энэхүү хуулийн төсөл дээр боловсон хүчнээ илүү хадгалж үлдэх тал дээр, мөн тэднийг хөдөлмөрлөх, ажиллах нөхцөлөөр нь илүү сайн хангах дээр анхаарах нь зүйтэй гэж харж байгаа.

Миний бие энэ хуулийн төслийг санаачилсан гишүүдийн нэг болж гарын үсэг зурсан. Тэгээд гол санаачилж байгаа Энхтуяа гишүүнийг шүүмжлээд байгаа нэг зүйл байгаа, хэтэрхий олон гишүүнээр зуруулсан байна. Тэгээд өөрөө ажлын хэсэгт орох боломжгүй болчихоод ингээд сууж байна. Тийм учраас ийм нийгмийн хэрэгцээг харж ингэж оруулж ирж байгаад 1 дүгээрт талархал илэрхийлье, 2 дугаарт дэмжиж

байгаагаа илэрхийлье, 3 дугаарт цаашдаа ч гэсэн өөрийнхөө санал бодлыг ажлын хэсгийн гаднаас оруулж явах болно гэдгээ илэрхийлье. Баярлалаа.

П.Ганзориг: Баярлалаа. Амгаланбаатарын Ганбаатар гишүүн үг хэлье. Нарантуяа-Нара гишүүнийг үг хэлэх гишүүдийн нэрс дээр нэмье.

А.Ганбаатар: Энхтуяа гишүүнтэй энэ хуулийн төслийг хамтран өргөн барьсан үндсэн шалтгаан бол хуучин социализмын үед 16, 17 Батсүмбэрийн асрах газар гэж бидний хуучин ойлголтоор хэдэн ядруухан хөгшин тэнд очоод байж байдаг нэг ийм газраар төсөөлөөд байдаг асрах үйлчилгээг. Орчин үед тэр мөнгөн эдийн засаг гэдэг чиглэл рүү нь шинэчилсэн бодлогоор энэ хуулийн төсөл орж ирж байгааг дэмжиж байгаа. Тухайлбал энэ нийгмийн даатгал, хувийн хэвшлийнхэнтэй холбоод зөвхөн төрөөс асуудлыг нь бүрэн шийдэх хэлбэрээр биш, гол нь хувийн хэвшилтэй хамтарч ажиллаж, энийг цааш нь унагачихгүй, зөвхөн төрийн татаастай байдаг биш, хувийн хэвшил, тухайлбал бизнесийн байгууллага болгож энэ хуулийн төсөлд тусгачихсан байж байгаа.

Тэгээд Энхтуяа гишүүн маш олон газартай уулзаж, гадаад, дотоодын байгууллагуудтай хамтраад туршлагыг нь сайн судлаад ингээд Монголд нутагшихад бэлэн болсон. Дээхэн үеийн бид ахмад хөгшчүүлээ асарна гэхээр гэртээ ач зээ харах байдлаар нэг хажуу өрөөндөө ингээд байгаад байдаг нэг ийм сэтгэлгээгээр хандаад байсан, заавал ахмадуудаа хажуудаа байлгаж байж асардаг ч юм биш болчихоод байна л доо. Орчин үед залуучууд, хүмүүс бүгдээрээ ажил бизнестэй болсон учраас ахмадууд өөрсдийнхөө энэ community-г бий болгох энэ хуулийн гаргалгаа төсөл нь бий болж байгаа юм.

Нэг хүмүүнлэг талаасаа энэ хуулийг дэмжээд байгаа юм нь болохоор энэ ахмадуудын ганцаардлын үнэр гэж байдаг юм байна. Энэ ганцаардлын үнэр гэдэг өөрөө хамаг өвчнийх нь уурхай болж байдаг, бид сэтгэл бэтгэрнэ гэж ярьж байдаг. Ахмадууд хамтдаа нэг хамт олон болоод нэг community болоод бие биеийгээ хараад, тухайлбал зарим нэг ажил төрөл эрхлээд ингээд хамт байх юм бол энэ өвчин, үнэр танар нь байхгүй болчихдог юм гэнэ билээ. Тэгэхээр энэ их хүмүүнлэг, дээр нь эрүүл мэнд, ахмадуудын дундаж наслалт, урт наслалтад нь оруулж байгаа их буян заяа оруулж байгаа ийм хуулийн төсөл юм. Ингээд дэмжсэн 60 хэдэн гишүүн байгаа юм байна. Тэгээд УИХ дээр манай гишүүд маань дэмжээд, Байнгын хороо маань дэмжээд энэ хуулийн төсөл амьдралд хэрэгжээсэй гэж хүсэж байна. Баярлалаа.

П.Ганзориг: Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн үг хэлье.

М.Нарантуяа-Нара: Юуны өмнө энэ хуулийг санаачилсан Энхтуяа гишүүндээ талархал дэвшүүлье. Бид ажлын хэсгээр бүгдээрээ анх 2025 оны 2 сард Япон улсын Токио хот болон Шизуока мужид яг энэ асрахуйн ажлын судалгаагаар явж байсан. Тэгээд тэр үед маш их зүйлийг бодитоор мэдэж авч, маш тэр ажлын хэсэг явж ирснээсээ гадна маш олон уулзалтуудыг хийсэн. Тэндээсээ хойш манай Энхтуяа гишүүн маань ялангуяа энэ хуулиа бүр барьж аваад, маш олон газруудад дахин нэмэлт судалгаагаар яваад, тэгээд энэ хуулийг бүрэн төсөл болгоод оруулж ирсэн, бидний гишүүд хамтдаа, ажлын хэсэгт орсон бүх гишүүд хамтдаа өргөн барьсан байгаа. Тэгээд энэ хуулийг УИХ-д нийтээрээ дэмжинэ гэдэгт итгэлтэй байна, дэмжээрэй гэж уриалах болно.

Ер нь ахмадын асуудал маш чухал асуудал болсон. Урьд нь хэдийгээр Монгол Улс ахмадаа асардаг, нялхсаа тэтгэдэг ийм уламжлалт соёлтой боловч сүүлийн жилүүдэд, ялангуяа энэ нийгэм, эдийн засгийн асуудал, энэ хүндрэл, цаг хугацааны энэ асуудал байдлаас болоод ер нь хөгшчүүд гэртээ ганцаараа байх, энэ гэртээ ганцаараа байхдаа тулгамдаж байгаа эрүүл мэнд, сэтгэл санааны маш олон, олон асуудлууд тулгамдаж байгаа асуудлыг тэр болгон хүмүүс төдийлөн хөндөөд байдаггүй ийм асуудлыг шигтгэж өгсөн байгаад үнэхээр таатай байна. Тэгээд энэ хуулийн төслийг дэмжинэ. Тэгээд нэлээн олон, яаж бид энэ дээр хамгийн гол нь хүний нөөцөө яаж бэлтгэх вэ, хүний нөөц, бэлтгэсэн хүний нөөцөө хэрхэн яаж сургах вэ, чадавхжуулах вэ гэдэг энэ асуудлууд их чухал байгаа. Тэгэхээр энэ асуудлуудаа бүгдээрээ яг энэ хуулийн хэлэлцүүлэг дунд бүр сайхан сайжруулаад, баталгаатай болоод, олон талын хүчин зүйлээс нь дэмжээд явна гэдэгт итгэлтэй байна.

П.Ганзориг: Гишүүд үг хэлж дууслаа. Та бүхэнд нэг баярт мэдээ дуулгахад өнөөдөр Засгийн газраас Оюутолгойн гэрээ хэлэлцээрийн асуудлаар хэлэлцээр хийж, Оюутолгойн зээлийн өндөр хүүг 10.5 байсныг 7.9 болгож бууруулж, 2.6 нэгжээр бууруулсан байна. Тэгээд өнгөрсөн 16 жилийн хугацаанд энэ Оюутолгойн асуудлаар анх удаа нээлттэй сонсгол явуулж, 2025 оны 12 дугаар сарын 8-наас 10-ны өдрүүдэд УИХ-аас ондоо багтааж Засгийн газарт чиглэл өгсөн тогтоол баталсан. Энэ дээр Оюутолгойн өндөр зээлийн хүүг бууруулах ийм чиглэлийг өгсөн. Энэ дээр ажилласан Батнайрамдал гишүүн болон Оюутолгойн Хянан шалгах түр хороонд ажилласан нийт гишүүд, УИХ-ын тогтоолыг баталсан нийт гишүүддээ талархал илэрхийлье. Ингэснээр Монгол Улс Оюутолгойн зээлд асар өндөр хүү төлж байгаа, энэ хүү маань тодорхой хэмжээнд буурч байгаа юм байна гэдгийг дуулгая.

Ингээд УИХ дээр Нийгмийн даатгалын ерөнхий хуулиар санал хураалтууд явагдаж байгаа тул уг санал хураалт дуустал 30 минутын хугацаанд Байнгын хорооны хурлыг түр завсарлуулъя.

Хуралдаан 18 цаг 27 минутаас 18 цаг 56 минутад завсарлав.

Байнгын хорооныхоо хурлыг үргэлжлүүлж явуулъя. Байнгын хорооны эрхэм гишүүд хурлын танхимдаа хүрэлцэн ирнэ үү. Гишүүд ирцийн санал хураалт явуулчихъя. Эхлээд санал хураалтад бэлтгэх юм байна. Ирцийн санал хураалт. А.Ариунзаяа, О.Батнайрамдал, Ж.Галбадрах, А.Ганбаатар, Д.Ганмаа, М.Ганхүлэг, Т.Мөнхсайхан, М.Нарантуяа-Нара, Б.Түвшин, Г.Хосбаяр, Ж.Чинбүрэн, Д.Энхтуяа нарын гишүүд Байнгын хорооныхоо хурлын танхимд орж ирэхийг хүсье. Ингээд хууль санаачлагч өөрөө энэ санал хураалтдаа орж ирж саналаа өгөхийг хүсье. Энхтуяа гишүүнийг урьж байна.

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл тус бүрээр 7 санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлдэнэ үү. Санал хураалтад ороогүй гишүүдээс бүгд ороод ирчихсэн байх шиг байна.

1.Асрах үйлчилгээний тухай анхдагч хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 22 орсноос 12 гишүүн дэмжиж, санал 54,5 хувиар дэмжигдлээ.

2.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 22 гишүүн оролцсоноос 13 гишүүн дэмжиж, санал 59,1 хувиар дэмжигдлээ.

3.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 22 гишүүн орсноос 13 гишүүн дэмжиж, 59.1 хувиар санал дэмжигдлээ.

4.Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 22 гишүүн орсноос 13 гишүүн дэмжиж, санал 59.1 хувиар дэмжигдлээ.

5.Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 22 гишүүн орсноос 12 гишүүн дэмжиж, санал 54.5 хувиар дэмжигдлээ.

7.Асрах үйлчилгээний тухай анхдагч хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 22 гишүүн орсноос 13 гишүүн дэмжиж, санал 59.1 хувиар дэмжигдлээ.

УИХ-ын гишүүн Д.Энхтуяа нарын 65 гишүүн 2026 оны 6 дугаар сарын 22-ны өдөр өргөн мэдүүлсэн Асрах үйлчилгээний тухай анхдагч хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг төсөл тус бүрээр санал хураалт явуулж дууслаа. Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Эрдэнэбат гишүүн танилцуулна.

19.03 цаг

Дараагийн асуудалдаа оръё. УИХ-ын гишүүн С.Эрдэнэбатаас Боловсролын сайдад хандаж тавьсан Боловсролын салбарын багш, ажилчдын нийгмийн баталгааны талаарх асуулгын хариуг хэлэлцэнэ. Эрдэнэбат гишүүн горимын санал хэлье гэнэ. Эрдэнэбат гишүүний микрофоныг өгье.

С.Эрдэнэбат: Боловсролын сайд хүндэтгэн үзэх шалтгаантай байгаа учраас би Боловсролын сайдын өөрийнх нь амнаас сонсмоор байгаад байгаа юм. Тэгээд энэ нэлээн нухацтай асуудлууд байгаа учраас хойшлуулъя энэ удаад.

П.Ганзориг: Эрдэнэбат гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Энэ асуудлыг хойшлуулъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 22 гишүүн орсноос 13 гишүүн дэмжиж, 59.1 хувиар санал дэмжигдэж, өнөөдрийн хэлэлцэх асуудлаас хойшлууллаа.

Гурав.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн биелэлтэд хяналт шалгалт хийж, холбогдох санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт

Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн биелэлтэд хяналт шалгалт хийж, холбогдох санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэж эхэлье. Санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Отгоны Саранчулуун танилцуулна. Танилцуулга хийхийг хүсье.

О.Саранчулуун: Сайн байцгаана уу. Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол УИХ-ын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны 2025 оны 2 дугаар тогтоолоор Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн биелэлтэд хяналт шалгалт хийж, холбогдох санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар О.Саранчулуун миний бие, гишүүдэд УИХ-ын гишүүн А.Ариунзаяа, Б.Бейсен, Д.Ганмаа, Т.Мөнхсайхан, Ц.Мөнхтуяа, М.Сарнай, Л.Энхнасан, М.Энхцэцэг, С.Эрдэнэбат нарын бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэйгээр УИХ-ын Тамгын газар, УИХ-ын гишүүдийн ажлын алба, Хяналт шалгалтын газар, холбогдох яамдын төлөөлөл оролцон 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс 2026 оны 6 дугаар сарын 25-ны хугацаанд хамтран ажиллалаа.

Ажлын хэсгээс Нийгмийн эрүүл мэндийн асуудлаар Эрүүл мэндийн, Боловсролын яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, ХАБЭАҮТ, СЭМҮТ, Зоонозын өвчин судлалын үндэсний төв, ДЭМБ, төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, эрдэмтэн судлаачдын төлөөллийг оролцуулан Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн биелэлт, тогтолцооны асуудал, удирдлага, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаа, санхүүжилт, хүний нөөц, нийгмийн эрүүл мэндийн лаборатори, хүнсний асуудал, нийгэм, сэтгэц, зан үйл, хөдөлмөрийн орчны болон эрүүл мэнд, эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг, засаглалын талаар мэдээлэл сонсон, нөхцөл байдалтай танилцаж саналыг авч ажилласан.

Ажлын хэсгийн хуралдаан болон зохион байгуулсан хэлэлцүүлэг, уулзалтын үеэр эрүүл мэнд, боловсрол, хүнс, хөдөлмөр, нийгмийн хамгааллын байгууллага, эрдэмтэн, судлаач, иргэдээс хуулийн хэрэгжилт, салбарын бодлого, хууль тогтоомжийн уялдаа холбоо, дүрэм журмыг батлуулах, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах талаар гаргасан санал, хүсэлт, тулгамдаж буй асуудлуудыг нэгтгэн тоймлож, цаашид эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, салбар дундын уялдаа холбоог сайжруулах шаардлагатай байна гэж үзлээ.

Ажлын хэсгийн үйл ажиллагааны хүрээнд Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн биелэлт, нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог оновчтой болгох эрх зүйн орчны талаар дараах санал, дүгнэлтийг танилцуулж байна. Ажлын хэсгийн дүгнэлт.

Монгол УИХ 2024 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг баталсан бөгөөд хууль хэрэгжиж буй 2 жилийн хугацаанд 3 сайд солигдож, хүний нөөц, засаглал, салбарын бодлогын хувьд тогтворгүй, хуулийн хэрэгжилт хангалтгүй, нийгмийн эрүүл мэндийн замын зураглал, эрүүл мэндийн салбарын 2026-аас 2029 оны стратеги төлөвлөгөө зэрэг батлагдаагүй байна нэг.

2-т нь, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуульд заасны дагуу боловсруулан гаргах 4 журам, 2 байгууллагын бүтэц батлагдаагүй байгаа нь хуулийг бүрэн хэрэгжүүлэх, салбар дундын зохицуулах нөхцөл бүрдээгүй, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээрх үйл ажиллагаа хангалтгүй байна. Тухайлбал, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 6.2.Энэ хуулийн 6.1-д заасан зөвлөлийн шийдвэр нь дүгнэлт, зөвлөмж хэлбэртэй байх бөгөөд зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Ерөнхий сайдын санал болгосноор Засгийн газар батлах, 7.1.1.Нийгмийн эрүүл мэндийн мэдээллийн сангийн ажиллах журмыг Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах, 7.1.2.Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед тохиолдлын удирдлагын тогтолцоогоор ажиллах журмыг гамшгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах, 19.5.нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц төлбөрийн хэмжээ, санхүүжүүлэх, төлбөртэй тусламж, үйлчилгээний төрөл, орлого, хандив, тусламжийг зарцуулах журмыг эрүүл мэндийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлах, 15.3.нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд олон нийтийн оролцоог хангах, сайн дурын ажилтныг урамшуулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэж тус тус заасан байгаа.

Монгол Улсын хэмжээнд хүн амын эрүүл мэнд, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хариу арга хэмжээ авах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, иргэдийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлэх, өвчний хяналт, сэргийлэлтийн үйл ажиллагаа зохион байгуулах чиг үүрэг бүхий төвийг Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 52 дугаар “Өвчний хяналт, сэргээлтийн үндэсний төв байгуулах, дүрэм батлах тухай” тогтоолоор баталсан хэдий ч байгууллагын бүтэц батлагдаагүй, хүн амын төвлөрөл, газар нутгийн байршлыг харгалзан нийгмийн эрүүл мэндийн төвийн бүтэц, журмыг боловсруулан батлуулах шаардлагатай байна. Түрүүний дээр дурдсан хуулийн заалтууд хэрэгжээгүй байгаа гэсэн үг.

3-д нь, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд нийгмийн эрүүл мэндийн хэрэгцээ бусад хуулиудтай хийдэл, давхардал ямар байгаа талаар судалгаа, мэдээлэл дутмаг байна.

4-т, эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчийг дэмжих ажлын хүрээнд үйлчлүүлэгч эмнэлэгт хэвтэх болон гарах үед нь нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, эмнэлгээс гарсны дараах тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, үйлчлүүлэгчийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээнд холбон зуучлах үйл ажиллагааг зохион байгуулахад чиглэсэн эмнэлэгт хэвтэх болон гарах үеийн төлөвлөлтийн үйл ажиллагааны талаар салбарын хэмжээнд нэгдсэн зохицуулалтыг бий болгох тушаал, шийдвэрийг боловсруулж мөрдлөг болгох шаардлагатай байна.

5.Боловсролын салбарын хувьд үндэсний хэмжээнд сурагчдын сэтгэл зүйн асуудлыг илрүүлэх нэгдсэн судалгаа шаардлагатай. Мөн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт ажиллаж буй сэтгэл зүйчийг чадваржуулах, эцэг, эх, асран хамгаалагчийн сэтгэл зүйн боловсролыг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай байна.

6.Түүнчлэн бага ангийн суралцагчдыг үдийн хоолонд хамруулахаас гадна үдийн хоолны үйлчилгээг өргөжүүлэх хүрээнд дунд, ахлах ангийн суралцагчдыг үдийн хоолонд хамруулах бодлогыг хэрэгжүүлэх төсөв, санхүүжилтийг шийдвэрлэх эх үүсвэрийг бий болгох. Үдийн хоолны төрийн худалдан авалтын хүнсний бүтээгдэхүүнд тавигдах шаардлагад Баяжуулсан хүнсний тухай хуулийн 4.1.1-д заасан баяжуулсан хүнсийг зайлшгүй шаардлага болгох, стандартын бус нөхцөлд хоол үйлдвэрлэж байгаа гал тогоог цэгцлэх, бүх сургуулийг аяга таваг угаагчаар хангах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

7.Иргэдийн эрүүл мэндийн боловсролын бодит түвшнийг тогтоох үндэсний хэмжээний үнэлгээ хийх, үүнд үндэслэн эрүүл мэндийн боловсрол олгох үндэсний стратеги боловсруулах, санхүүжилтийг шийдвэрлэх, иргэдэд эрүүл зан үйл төлөвшүүлэх үйл ажиллагаа, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлээс шалтгаалсан үр дагаврыг даван туулах, сөрөн тэсвэрлэх сэтгэл зүйн үйлчилгээний эрх зүйн зохицуулалт, санхүүжилт, хэрэгжилтийн үр дүнг үнэлэх үнэлгээний нэгдсэн тогтолцоо, урамшуулал, хариуцлагын механизмыг бүрдүүлэх хэрэгтэй байна.

8.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангахад салбарын хүний нөөцөд онцгой анхаарал хандуулах хэрэгтэй байна.

9.Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах, эрсдэлт хүчин зүйл, өвчин эмгэгийг илрүүлэх үйл ажиллагаа зогссон, хэзээ үргэлжлэх нь тодорхойгүй байна.

10.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн багц төлбөрийн хэмжээ, бүтэц оновчгүй, эх үүсвэр тодорхойгүй, нарийвчилсан зохицуулалтгүй байна.

11-д, 2024 оны 6 дугаар сарын Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, чихэр, чихэр орлуулагч агуулсан төрөл бүрийн ундаа, усанд онцгой татвар ногдуулж, 2027 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжихээр баталсан. Чихэрлэг ундааны татварын хувьд татвар ногдуулах болон чөлөөлөх ундааны ангилал тодорхойгүй байна.

12.Транс тосны зохицуулалтын тухайд хүнсний бүтээгдэхүүний орц, найрлагыг өөрчлөх цогц хууль, эрх зүйн зохицуулалт байхгүй, сургуулийн орчноос гадуурх хамгаалалт хангалтгүй байна. Эрүүл мэндийн сайдын 2018 оны А346 дугаар тушаалаар хүүхдэд чиглэсэн хүнсний зар сурталчилгааг зохицуулах удирдамжийг батлан мөрдөж байгаа ч хэрэгжилт хангалтгүй байна. Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах арга хэмжээний төлөвлөгөө 2026-аас 2028 онд тусгагдсан ДЭМБ-ын "REPLACE" техникийн багцын зөвлөмжид үндэслэн хүнсний бүтээгдэхүүн дэх транс тосны агууламжийг хуулиар хязгаарлах буюу хэсэгчилсэн устөрөгчжүүлсэн

тосыг хүнсний үйлдвэрлэлд ашиглахыг хориглох цогц эрх зүйн зохицуулалт боловсруулах шаардлагатай байна.

13-д нь, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хөдөлмөрийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой зохицуулалтад хамтарсан дүн шинжилгээ хийж, эрх зүйн давхардал, хийдлийг арилгах шаардлагатай байна. Ийм учраас ажлын хэсгийн үйл ажиллагааны үр дүнд үндэслэн дараах зөвлөмжийг чиглэл чиглэлээр гаргасан байгаа, энийг нь хавсралтаар оруулсан байгаа. Баярлалаа.

П.Ганзориг: Эрхэм гишүүдээ, Саранчулуун гишүүн маш чухал санал, дүгнэлтүүд уншиж байгаа тул анхаарлаа нааш нь хандуулаарай. Саранчулуун гишүүндээ баярлалаа. Тэгээд танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Чинбүрэн гишүүнээр тасаллаа. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн асуулт асууя.

М.Ганхүлэг: Чухал ажлын хэсэг дүгнэлтээ өнөөдөр Байнгын хорооны хуралд танилцуулж байгаа юм байна, ганц нэгэн зүйлүүдийг тодруулж асууя. Нэлээн нухацтай судалгааны ажлууд байх шиг байна. Ер нь хуулийн хэрэгжилт, түүнтэй холбогдолтой хувь хэмжээг, Саранчулуун гишүүнээ, хувь хэмжээг илүү дэлгэрүүлж тодруулъя. Учир шалтгаан нь юунаас болж байна вэ гэдгийг та дэлгэрүүлж хэлээрэй. Ер нь Байнгын хороодоор орж ирж байгаа энэ хуулиуд дандаа хэрэгжилтийн хувьд дутагдалтай байгаад байна. Үүнтэй холбоотой илүү хяналт шалгалтыг сайжруулах чиглэлийн зохицуулалтыг цогцоор нь авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага байна гэдгийг онцлоод хэлье.

Энэ 6 дугаар зүйл дээр зориулалтын бус гал тогоог цэгцлэх, бүх сургуулийг аяга таваг угаагчаар хангахтай холбоотой асуудал дурдсан байна. Жишээлбэл, яг хэчнээн сургууль дээр ямар ноцтой байдлууд бүртгэгдсэн байна вэ? Энийг тодруулж асууя. Энэ наад захын л шаардлага, хэрэгцээ байна шүү дээ, тэгээд энийгээ хангаж чадахгүй байгаатай холбоотой ямар тоо, статистик мэдээллүүд байна вэ гэдгийг тодруулж асууя?

Энэ чиглэлээр ажиллаж байгаа Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн ажилтнуудын 40 хувь нь тухайн жилдээ ажлаасаа гарч байна гэж байна л даа. Учир шалтгаан нь юу байх вэ? Тэгээд хамгийн ихдээ нэг жил орчим ажиллаад, тэгээд үндсэндээ ажлаа өгөөд байгаа асуудал байна шүү дээ, нийтлэг нэлээн тохиолдож байгаа асуудал байна. Тэгэхээр энэ ямар учир шалтгаантай байна вэ, яаж шийдвэрлэх вэ гэдэг дээр ажлын хэсэг ямар дүгнэлт гаргасан бэ гэдгийг тодруулъя?

П.Ганзориг: Ажлын хэсгийн ахлагч Саранчулуун гишүүн хариулъя.

О.Саранчулуун: Ганхүлэг гишүүнд баярлалаа. Яах вэ, том зургаараа Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль батлагдаад 2 жил гаран болж байгаа боловч хуулийг хэрэгжүүлэх хамгийн гол механизм, бүтэц болох зөвлөл нь бүрдээгүй бараг 2 жил болчихсон. Зөвлөл нь бүрдээд Нийгмийн эрүүл мэндийнхээ хуулийг орон даяар хэрэгжүүлэх бүтэц болох Өвчний хяналт, сэргийлэлтийн үндэсний төвийнх нь бүтэц, зураглал нь гараагүй байгаа. Энэ нь

өөрөө энэ хуулийн хэрэгжилтийг үнэлэх, үр нөлөөг үнэлэх ямар ч бололцоогүй ийм нөхцөл байдалд орчихлоо гэдэг дүгнэлт үндсэндээ гаргаж байгаа.

2 дахь хэсэг нь болохоор 6 дугаар дүгнэлтээр бага ангийн суралцагчдын үдийн хоолны асуудал байгаа. Үдийн хоолны асуудал дээр баяжуулсан хүнсийг зайлшгүй шаардлага болгох, стандартын бус нөхцөлд хоол үйлдвэрлэж байгаа гал тогоог цэгцлэх, бүх сургуулийг аяга таваг угаагчаар хангах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна гэсэн дүгнэлт хийсэн байгаа. Энэ дээр би эхэлж хариулаад, Ганмаа гишүүн нэмж хариулж болох байх. Ер нь жил хагасын өмнө хоол хүнсний нэгдсэн судалгаа хийгээд, хүүхдүүдийн хоолны дунд сургуулийн хүүхдүүдийн эрүүл мэндийн үнэлгээ дээр хоолны буюу хоол боловсруулах эрхтний, яг тэр хооллож байгаа процесстой холбоотой судалгаа, мөн хүүхдүүдийн эрүүл мэндийн судалгаа хийсэн юм билээ. Тэгээд тэр судалгаан дээр хүүхдүүдийн эрүүл мэндийн асуудал дээр хоол боловсруулах замын өвчлөл нэлээн өндөр гарсан учраас ийм дүгнэлтүүд гарсан байгаа. Энэ дээр ямар нэгэн урьдчилсан бодлого, тогтолцоо, зураглал гаргаагүй байгаа учраас ийм дүгнэлт гарсан байгаа. Яагаад баяжуулсан хүнстэй холбоотойг нь Ганмаа гишүүн хариулж болно.

Сүүлийн асуулт нь болохоор ажил эрхлэлтийн тухай асуусан. Дунджаар 40 хувь нь 3-аас 4 жил болоод ажлаасаа гардаг энэ салбарын хүний нөөцийг асуулаа гэж би ойлгосон зөв тийм ээ? Нийгмийн эрүүл мэндийн салбарт хүний нөөцийн асуудал нь тархвар зүйч, хоол зүйч, ХАБЭА-н ажилтан, нийгмийн эрүүл мэнд судлаач, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч гээд хүмүүс ажиллаж байгаа. Энэ хүмүүсийн хувьд ажлын байран дээрх хөдөлмөрийн тодорхойлолт, ажлын байрны чиг үүрэг нь яг Нийгмийн ажлын тухай хууль, сэтгэл зүйн үйлчилгээ гэдэгтэй адилхан одоохондоо жигдрээгүй, тэр нь нөгөө л нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зураглал маань эцэслээгүйтэй холбоотой. Тэгэхээр ядаж л энэ салбарт яг хичээл дээрээ заасныхаа дагуу ажиллангуут ажил дээр гарахаараа заримдаа ажил мэргэжил нь хоорондоо давхцах агуулга гараад байдаг. Нийгмийн эрүүл мэнд буюу нийтийн эрүүл мэндийг аль нь тархвар зүйн судалгаа хийгээд, аль нь 1 дүгээр үе шатны урьдчилан сэргийлэлт байх юм, аль нь 2 дугаар үе шатны урьдчилан сэргийлэлт байх юм гэдэг нь ялгаж салгаагүй байсаар л байгаа учраас зарим хүмүүс яг нийгмийн ажилтнуудын кэйстэй адилхан ажлаасаа дунджаар солигддог гэсэн үг. Дунджаар 3 жил ажиллаад хөдлөөд явдаг. Энэ дээр маш олон төгсөгчдийн маань санал, гомдлууд байгаа.

Тэгэхээр хуультай болсон гээд байгаа мөртөө энэ салбарт ажиллаж байгаа, хөтөлбөр нь хэрэгжээд сурсан 6 төрлийн мэргэжилтнүүд маань ажлын байран дээр тогтвортой байдал хангагдаагүй л байгаа гэсэн үг. Тэгэхээр шалтгаан нь ажлын байрны тодорхойлолт, карьерын тодорхой бус байдал, эрх зүйн орчин, нийгмийн баталгаа гэдэг асуудлууд бас яг адилхан давхцаж байгаа гэсэн үг.

П.Ганзориг: Тодруулах уу, гүйцээж хариулах юм уу? Ганмаа гишүүн нэмэлтээр хариулъя.

Д.Ганмаа: Ганхүлэг гишүүн хүнсний баяжуулалттай холбоотой асуулт нэмж асуусан байна. Хүнсний баяжуулалт дээр энэ санал нь бид сүүлийн бараг 20 жил Монголд хийгдсэн судалгаагаараа харахад, жишээлбэл хүнсний баяжуулалттай Д витаминаар баяжуулсан сүүг, Д витаминаар баяжуулаагүй сүү, жишээлбэл тэрэн дээр манайх нэг хүнсний хууль ч юм уу, хөдөө аж ахуйн хуулиудыг ороод харахаар

зэрэг нэг л калори яриад байгаа байхгүй юу. Калорийн тухай л яриад байгаа, тэдэн хувийн калори нь хүрч байгаа, хүрэхгүй. Калорийг дан гурилаас, дан чихрээс ч аваад байж болдог байхгүй юу. Тэгэхлээр гол нь бичил шим тэжээл авах гэж л хүн хоол унд иддэг, бичил шим тэжээл нь хангалттай байж, нөгөө энерги нь байж хүүхэд эрүүл саруул өснө, тархины хөгжил нь сайжирна, амьсгалын замын хурц халдварт өвчин нь буурна. Яг үүнтэй холбоотой судалгаануудыг сүүлийн яг Монгол хүүхэд, хүмүүсийн хөгжил дээр, эмэгтэйчүүд дээр хийсэн судалгааны үндсэн дээрээ Баяжуулсан хүнсний тухай хуулийг 2017 онд хийсэн байхгүй юу.../минут дуусав/

П.Ганзориг: Ганхүлэг гишүүн тодруулъя.

М.Ганхүлэг: Ерөнхий хандлагыг ойлгож байгаа, ажлын хэсгийг би дүгнэлтээ илүү тодорхой гаргаж өгөөсэй гэж хүсээд байгаа юм. Нэгд, энэ хуулийн бүхэлд нь үндсэндээ ямар журмаар дүгнэдэг юм, тодорхой хувиар дүгнэх хэрэгтэй. Хэрэгжээгүй гэвэл хэчнээн хувь гэж үзэж байгаа юм бэ? Ерөнхийдөө хэрэгжээгүй гэдэг ийм дүгнэлт гаргах нь зөв үү, буруу юу гэдэг дээр та хэд маань анхаарлаа хандуулаад, хэрэгжээгүй бол 10 бол 10 хувь, 20 бол 20 хувь гэдгээр нь гаргаж өгөх нь зөв байх гэж бодож байгаа юм.

2 дахь асуулт нь болохоор, яг сум, орон нутаг, ерөнхий боловсролын сургуулиудын ямар судалгаагаар энэ гал тогоог нь сайжруулах шаардлагатай гэж яг яаж дүгнэсэн юм бэ гэж асуугаад байгаа байхгүй юу? Дахиад дээрээс нь тэр аяга таваг угаагч тэргүүтэй тодорхой анхан шатны, наад захын энэ хэрэгцээгээр нь хангаж чадахгүй байгаа асуудал дээр хэчнээн сургууль нь яг тийм байгаа юм бэ гэдгийг би тоо асуугаад байгаа юм? Тэр ажилтны хувьд 40 хувь нь ажлаасаа гарч байгаа нь цалин хөлснөөс байдаг юм уу яг.../минут дуусав/

П.Ганзориг: Ажлын хэсгийн гишүүн Ганмаа гишүүн хариулъя.

Д.Ганмаа: Манай ажлын хэсгээс өгсөн тоон дээр хариулъя. Нийт 66.1 хувь нь стандартын шаардлага хангасан, нийт 627 гал тогоо стандартын дагуу үйл ажиллагаа явуулж байна Монгол Улсын түвшинд. 33.9 хувь нь стандартын бус буюу 332 гал тогоо стандартын бус нөхцөлд хоол үйлдвэрлэж байна гэсэн тоо баримт байдаг юм байна. Жишээлбэл, сургууль гэхэд нийт 566 сургуулиас зөвхөн 68.5 хувь буюу 368 нь стандартын, дотуур байр 383-аас 239 буюу 62 хувь нь стандартын, бусад нь стандартын бус гээд. Ер нь үүнтэй холбоотой стандартын ажлын хэсэгт ажиллаж байхад дотуур байрууд, хот, хөдөөгийн сургуулиудаар явж энэ тоо баримтыг нэгтгэсэн байдлаар дүгнэж байсан. Тухайн үед гаргасан тооцоо. Яах вэ, нэмэлтээр нийт 949 гал тогооноос 566 сургууль нь, тэгээд 383 дотуур байр нь яг хоол бэлтгэх тийм.../минут дуусав/

П.Ганзориг: Ганхүлэг гишүүн тодруулъя.

М.Ганхүлэг: Бид жил болгон төсвөө батлахдаа боловсрол, эрүүл мэндийн салбар дээрээ ахиу байя, энд хуваарилагдаж байгаа урсгал зардлуудыг боломжоор нь тавьж өгье гэдэг ийм байдалтай байгаа шүү дээ. Тэгэхээр аяга таваг угаагчаасаа авхуулаад энэ үдийн цай хөтөлбөрт хамрагдаж байгаа сургуулийн гал тогоог ажиллах тэр бүрэн боломж, бололцоогоор нь бүрэн дүүрэн хангаж чадахгүй байна гэдэг дүгнэлт гарч байгаа юм байна. Тэгвэл урсгал зардалд ер нь хэчнээн төгрөг бид хуримтлуулаад, түүнийгээ юундаа зарцуулаад, алдаа нь юу байна вэ гэдгийг

Боловсролын яамнаас асууя? Боловсролын яам энэ дээр ямар санал улсын төсөвт оруулж ирээд, тэгээд тэрийг нь бид яаж хасаад, аяга таваг угаагчийг нь хүртэл хангаж өгч чадахгүй байдалд очоод байгаа юм бэ гэдгийг нэлээн тодруулаад хэдүүлээ ярилцчих нь зөв байх гэж бодож байна. Боловсролын яам энэ дээр урсгал зардалтай холбоотой ямар зохицуулалт хийж байгаа вэ гэдэг дээр хариулт өгөөч?

П.Ганзориг: Ганхүлэг гишүүн яг энэ тоотой холбоотой, нарийн тоон мэдээлэл асууж байна. Тэгээд Боловсролын яамнаас өнөөдөр төлөөлөл байхгүй болохоор ажлын хэсгийн ахлагч чиглэл өгөөд, Боловсролын яамнаас Ганхүлэг гишүүний асуусан асуултад бичгээр тодорхой хариулт хүргүүлэхийг хүсье. Чинбүрэн гишүүн асуултаа асууя. Чинбүрэн гишүүний микрофоныг нээе.

Ж.Чинбүрэн: Чухал ажил хийсэн, ажлын хэсгийнхэнд баярлалаа. Энэ Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны гол чухал хууль бол энэ Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль байгаа. Энэ хуулийн хэрэгжилтийн гол амин сүнс нь энэ Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөл. Тэгэхлээр Саранчулуун гишүүн энэ яг гол ажлыг олж харсан байна. Энэ Үндэсний зөвлөлийг бүр татан буулгачихсан байсан, ингээд 2025 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар буцааж байгуулах шийдвэрийг Эрүүл мэндийн сайд байхдаа оруулж буцааж батлуулсан. Үүнтэй холбоотойгоор 26 гишүүнтэй буюу Ерөнхий сайдаар ахлуулсан Үндэсний зөвлөл ажиллах ёстой. Ерөнхий сайдаар ахлуулдгийн гол зорилго нь салбар хоорондын уялдааг, эрүүл мэндийн бодлогыг бүх бодлогод шигтгэх ёстой гэсэн ийм зорилгоор бид энэ хуулийг анх баталж байсан.

Үүний хамгийн чухал ажлын том хөдөлгөгч нь Өвчний хяналт, сэргийлэлтийн үндэсний төв байх ёстой. Энэ маань үйл ажиллагаагаа эхлэхгүй удаж байгаа учраас энийг цааш нь явуулах ёстой. Тэгэхлээр би ажлын хэсгийнхнээс асуух гэж байгаа зүйл, хэдүүлээ Байнгын хорооноосоо энэ үйл ажиллагааг яаж эрчимжүүлэх юм бэ? Тэгэхлээр бид Засгийн газарт Байнгын хорооноосоо тогтоол гаргаж яах уу, эсвэл үргэлжлүүлээд сонсгол хийх үү? Танд ямар санал байна вэ? Энэ 2 зүйлийг л хийж чадвал үүний цаана байгаа.

Дараагийн нэг асуулт нь нийгмийн эрүүл мэндийн ажилтны цалин хөлсний асуудал нэлээн хөндөгдөж байгаа, бид энийг ярихгүй бол болохгүй. Эрүүл мэндийн тусламжийн чиглэлээр ажиллаж байгаа эмч, сувилагч нарын цалин нэмэгдсэн, ингээд хөдөө орон нутагт эрүүл мэндийн газарт ажиллаж байгаа нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр ажиллаж байгаа улсуудын цалин хөлс үнэхээр чамлахаар болсон, ажлаа хийж чадахгүй шилжиж байгаа зэрэг байдлуудыг та дурдлаа. Тэгэхлээр энэ дээр бид Байнгын хорооноосоо яах ёстой вэ гэдэг санал сонсьё.

П.Ганзориг: Ажлын хэсгийн ахлагч Саранчулуун гишүүн хариулъя. Энэ асуудлын дараа Нийгмийн даатгалын ерөнхий хуулиар 4 санал хураалт явагдах тул гишүүд танхимдаа орж ирэхийг хүсье.

О.Саранчулуун: Баярлалаа. Чинбүрэн гишүүнд маш их баярлалаа. Маш чухал, яг түрүүн танилцуулгадаа багтааж чадаагүй саналуудыг асууж байна. Энэ ажлын хэсгийн үр дүнд ингэмээр байгаа, УИХ бодлого, тогтолцооны түвшинд бидний зүгээс нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх зорилгоор энэ бодлого, замын зураглал, эрүүл мэндийн салбарын стратеги төлөвлөгөөг нь нэг харж, яг үүн дотроо шинээр байгуулсан Өвчний хяналт, сэргийлэлтийн үндэсний

төвийн үйл ажиллагааг эхлүүлэхэд нь бүгдээрээ нэг сонсгол хийдэг юм уу, заавал энэ рүү анхаарах хэрэгтэй байгаа 1 дүгээрт.

2-т гэвэл, хамгийн чухал нь нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тогтвортой санхүүжилтийг бий болгох зорилгоор тусламж, үйлчилгээний багц, бодит өртөг, төлбөрийн хэмжээг оновчтой тогтоож, санхүүжилтийн салангид эх үүсвэр, механизмыг хууль, бодлогын түвшинд боловсронгуй болгох хэрэгтэй байгаа.

3-д нь, ерөөсөө нийгмийн эрүүл мэнд, энэ нийтийн эрүүл мэнд гэдэг чинь хоол байхгүй юу. Тэгэхээр эрүүл зөв хооллолтыг дэмжих зорилгоор эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй зарим төрлийн чихэрлэг ундаа, транс тос агуулсан хүнсний бүтээгдэхүүний зар сурталчилгааны асуудлууд зэргийг хуульд тусгаж зохицуулах хэрэгтэй байгаа.

4-д нь, сурагчдын эрүүл мэндийг дэмжих зорилгоор дунд, ахлах ангийн суралцагчдыг үдийн хоолонд хамруулах тогтолцоог бүрдүүлэх тэр эрх зүй, санхүүжилтийг хөндөх хэрэгтэй болж байгаа. Хамгийн чухал нь Нийгмийн эрүүл мэндийн тухай хуулийн нэг чухал зорилго бол энэ сэтгэл зүйн, сэтгэцийн эрүүл мэндийн асуудал байгаа. Тэгэхээр энэ дээр жишээлбэл бид хүн амын сэтгэл зүйн тусламж, үйлчилгээний зохицуулалтыг Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуультай уялдуулж шинэчлэн боловсруулах, цаашид салбар хоорондын хамтын ажиллагааг хангах чиглэлээр заавал үйл ажиллагаа явуулах хэрэгтэй. Ийм 5 зөвлөмж байгаа юм.

Ингээд задлаад үзэхээр Засгийн газарт жишээлбэл хийх ёстой ажлууд нь ЭМЯ-ны манлайлал шаардсан хэд хэдэн ажлууд байна. Түрүүний замын зургийг гаргаад танилцуулах, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнийхээ хуульд багтаачихсан одоо хүртэл батлаагүй байгаа дүрэм журмуудаа батлах хэрэгтэй байна. Энэ бол Засгийн газрын цэвэр, ЭМЯ-ны өөрсдийнх нь манлайллын асуудал байгаа. Мөн эрүүл мэндийн байгууллагад үйлчилгээ үзүүлж байгаа хүмүүстээ зориулсан зөвхөн бид чинь анхдагч урьдчилан сэргийлэлт гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр хоёрдогч, гуравдагч урьдчилан сэргийлэлтийн юмыг одоо байгаа менежментээрээ зарим юмаа хийчих хэрэгтэй гэх мэтээр. Засгийн газрын түвшинд засаглалын хувьд энэ 3-ыг хийгээд, урьдчилан сэргийлэлтийн тогтолцоо дээр үр дүнтэй урьдчилан сэргийлэлтийн тогтолцооны арга хэмжээ авах хэрэгтэй байна. Тэгэхгүй бол бүх хүнийг ингээд л бүгдийг нь нэгдсэн байдлаар ингэж скрининг хийх нь зардлын хувьд маш үр өгөөжгүй гэдгийг бид мэдэж байгаа учраас үүн дээрээ бид дахин шалгуур үзүүлэлтээ шинэчлэх хэрэгтэй байгаа.

Ерөнхий боловсролын сургууль, ер нь эрүүл мэндийн салбарт энэ нийт Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хуулийг хэрэгжүүлэгч гэдэг өнцгийг тэр хууль руу нь оруулж өгөхгүй бол яг нийгмийн эрүүл мэнд, нийтийн эрүүл мэнд гэхээр зөвхөн ЭМЯ, нөгөө НЭМҮТ-ийн үүрэг юм шиг ийм ойлголт, хандлагаар ерөнхийдөө байдаг юм байна лээ шүү дээ. Тэгэхлээр энийг нь баталгаажуулсан ийм эрх зүйн орчин руу анхаарах хэрэгтэй байна гэсэн ийм зөвлөмжүүдийг энэ дүгнэлтдээ хавсаргасан байгаа. Тэгээд хамгийн сүүлд нь нэмэх зүйл нь энэ хөдөлмөрийн эрүүл мэндийн тогтолцоо байгаа. Одоо Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль орж ирж байгаатай холбоотой бид энэ хөдөлмөрийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх агуулга руу нь нэлээн их оролцох ёстой ийм хавсралт санал гарсан байгаа Чинбүрэн гишүүнээ.

П.Ганзориг: Ж.Чинбүрэн гишүүн тодруулъя.

Ж.Чинбүрэн: Тэгэхлээр яаж бид Засгийн газрыг энэ үйл ажиллагаагаа эрчимжүүлэх вэ гэдэг шахалт, хяналтын механизмаа идэвхжүүлэх үү гэдэг нь өөрөө чухал. Тэгэхлээр бид Байнгын хороогоороо дараах ажлуудыг хийх бидэнд бүрэн боломжууд нь байж байна. Тухайлбал, Байнгын хорооны хяналтын сонсгол зохион байгуулж Үндэсний зөвлөл хуралдсан эсэх, хэдэн удаа хуралдсан юм, хуралдсан юм уу, ямар асуудлууд шийдсэн юм гэдгийг. Ингээд цочрол өгөхгүй л бол энэ хэзээ ч хуралдахгүй, хэзээ ч эхлэхгүй. Та бүхэн санаж байгаа бол сая хүүхдийн эрхтэй холбоотой хүүхдийн эрхийг хамгаалах үндэсний комисс сая хуралдлаа. Энэ их чухал хурал болсон. Тэрэнтэй адилхан бид ингэж шахаж өгөхгүй бол үйл ажиллагаа эхлэхгүй. Ялангуяа 27 оны төсөв хэлэлцэх үед Ганзориг даргаа бид төсөв хэлэлцэх үе дээр энэ асуудлыг заавал ярьчихсан байхгүй бол, шахалт үзүүлэхгүй л бол нийгмийн эрүүл мэндийн чиглэлд энэ үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа идэвхжих магадлал тун бага байгаа. Тэгээд бидэнд байгаа зөндөө аргууд байна. Жишээлбэл, Ерөнхий сайдад бид эрүүл мэндийн.../минут дуусав/

П.Ганзориг: Чинбүрэн гишүүн үг хэллээ. Тэгээд Чинбүрэн гишүүний хэлсэн энэ гол саналуудыг Байнгын хороон дээр анхаарч ажил хэрэг болгож ажиллана нийт гишүүдтэй. Гишүүд асуулт, хариулт явагдаж дууслаа. Үг хэлэх гишүүд байна уу? Алга байна. Үг хэлж дууслаа. Байнгын хорооны гишүүдийн хэлсэн саналуудыг, Байнгын хороон дээр саяын гишүүдийн хэлсэн саналуудыг анхаарч, ажлын хэрэгтээ тусгаж ажиллахыг холбогдох төрийн байгууллагуудаас хэлье.

19.31 цаг

Дараагийн асуудалдаа оръё. Шинжлэх ухаан, технологийн салбарыг улсын хөгжлийн бодлого, нийгэм, эдийн засаг, инновац, үйлдвэрлэлийн бодлоготой уялдуулан хөгжүүлэх талаарх Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын мэдээллийг сонсоно. Зулпхар гишүүн санал хэлье.

С.Зулпхар: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийнхээ оройн амгаланг айлтгая. Шинжлэх ухаан технологийн салбарын чиглэлээрх Эдийн засаг, хөгжлийн сайдын мэдээллийг сонсох учиртай. Энэ мэдээлэлтэй уялдуулаад бид тогтоолын төсөл бэлэн болгож байсан. Гэхдээ тогтоолын төсөлтэй холбогдуулаад тодорхой зарим асуудлаар төрийн захиргааны төв байгууллагуудаас тодруулга авах, нарийвчлан жишээ нь тоо авах ийм шаардлага гарсан учраас өнөөдрийн хэлэлцэх асуудлаас энэ асуудлыг хасах саналтай байна.

П.Ганзориг: Зулпхар гишүүн хэлэлцэж байгаа асуудлыг хойшлуулах горимын санал гаргасан тул санал хураалт явуулъя. Санал хураалтад бэлдье гишүүд. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Бусад нь болчихсон уу? Зулпхар гишүүний гаргасан горимын саналын дагуу санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 24 гишүүн орсноос 13 гишүүн дэмжиж, санал 54.2 хувиар дэмжигдэж, уг асуудал хойшиллоо.

Дөрөв.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд

/Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Б.Түвшин нарын гишүүд өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл, эцсийн хэлэлцүүлэг/

Сүүлийн асуудал. Засгийн газар болон УИХ-ын гишүүн А.Ариунзаяа, Б.Түвшин нарын гишүүд өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн нэгтгэсэн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Лхагвасүрэнгийн Мөнхзул Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх, Ванчингийн Рэнцэнханд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга, Баасангийн Батжаргал НДЕГ-ын дарга, Цэнд-Аюушийн Ганцэцэг НДЕГ-ын Бодлого хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга, Энхбаатарын Тамир МҮЭХ-ны ерөнхийлөгч, Баасангийн Алтанхуяг Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооны орон тооны бус дэд ерөнхийлөгч, Чимэдцэрэнгийн Нанжидсамбуу МАОЭХ-ны дэд ерөнхийлөгч, Энхтайвангийн Энхжаргал МАОЭХ-ны Хөдөлмөрийн харилцаа, эрх зүй, нийгмийн бодлогын газрын дарга, Бямбаагийн Мөнхбаяр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын ахлах шинжээч, Чимэдгочоогийн Өнөржаргал Санхүү, эдийн засгийн их сургуулийн багш, судлаач.

Байнгын хорооны хуралдаанд ажлын хэсгийн танилцуулгыг УИХ-ын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Хүрэлбаатарын Булгантуяа танилцуулна. Булгантуяа гишүүний микрофоныг нээе.

Х.Булгантуяа: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 6 дугаар сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл, УИХ-ын гишүүн Б.Түвшин нарын 41 гишүүн 2025 оны 5 дугаар сарын 9-ний өдөр өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл, УИХ-ын гишүүн А.Ариунзаяа нарын 8 гишүүн 2026 оны 6 дугаар сарын 4-ний өдөр өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг нэгтгэн, анхны хэлэлцүүлгийг 2026 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороонд шилжүүлсэн.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас өгсөн гүйцээн боловсруулах чиглэлийн дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасныг баримтлан зарчмын зөрүүтэй 4 саналыг бэлтгэн танилцуулж байна. Зарчмын зөрүүтэй саналыг та бүхэнд тараасан болно.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, ажлын хэсгээс боловсруулсан зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

П.Ганзориг: Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Ганхүлэг гишүүнээр тасаллаа. Ганхүлэг гишүүн.

М.Ганхүлэг: Эцсийн хэлэлцүүлэгтэй холбоотой учраас хууль хэрэгжүүлэхтэй холбоотой, яах вэ үндсэн санааг дэмжиж байгаа. 5 хүртэлх ажилтантай бол ингээд НДШ аваад эхлэхээр компаниуд хуваагдах, олон жижиг компаниуд бий болгох тийм эрсдэлүүд байгаа. Тэгээд үүнтэй холбоотой хэрэгжүүлэх явцад бид ямар ажлуудыг хийж болох вэ гэдэг дээр та бүхнээс нэмэлт тайлбар авъя? Эсрэгээрээ олон компани болох нь ямар сөрөг нөлөөллүүд байх вэ, эсвэл нэг их онцын нөлөөлөл байхгүй юу гэдэг дээр тайлбар авъя?

П.Ганзориг: Ажлын хэсгийн ахлагч хариулъя, Булгантуяа гишүүн хариулъя.

Х.Булгантуяа: Үүнийг хэлэлцүүлгийн явцад нэлээдгүй гишүүд асуусан. Компани жижиг болж задарч, НДШ чөлөөлөлтөд хамрагдахын тулд задрах вий, жижгэрэх вий гэдгээс сэргийлж, энэ шимтгэлийн чөлөөлөлтөд даатгуулагч зөвхөн нэг удаа хамрагдана гэж оруулсан байгаа. Ингэснээр нэг компанид очоод нэг хөнгөлөлт, чөлөөлөлт ажил олгогчид нь эдлүүлээд, дараагийн компанид очоод дараагийн хүнд нь хөнгөлөлт, чөлөөлөлт ажил олгогчид нь эдлүүлээд байхааргүй энэ хуулийн зохицуулалтыг 1 дүгээрт хийж өгсөн. Үүсгэн байгуулагчаар хийхэд их хэцүү юм билээ. Зарим үүсгэн байгуулагч 5, 10 хувийг ч байдаг юм уу, зарим нь 50, 60 хувь, зарим нь 100 хувь ч гэсэн хөрөнгийн эзэмшигч байх боломжтой учраас үүнийг бид ингэж хийж өгсөн. Мөн дээрээс нь нэмээд НДШ төлөгчөөр бүртгүүлсэн 5-аас, бүртгүүлсэн гээд өөрөөр хэлбэл тогтвор суурьшилтай ажлын байр олгож байгаа компаниудыг шинээр үүсгэхээс илүүтэйгээр бүртгүүлсэн, үйл ажиллагаа нь ерөнхийдөө явж байгаа компани гэж бид тооцож оруулж өгсөн.

П.Ганзориг: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг гүйцээн боловсруулж, хуулийн төслийн холбогдох зүйл, заалт, хэсэгтэй уялдуулахаар УИХ-ын даргаас чиглэл өгсөн бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтад заасны дагуу хураалгах зарчмын зөрүүтэй 4 саналын томъёоллоор санал хураалт явуулъя, саналын томъёоллыг танилцуулъя.

1.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалт буюу 21 дүгээр зүйлийн 21.29 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.29.Сүүлийн таван жилийн дотор нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгүүлсэн таваас ихгүй ажилтантай ажил олгогчийн гурав хүртэл ажилтны ажил олгогчийн төлөх энэ хуулийн 6.1.1, 6.1.2-т заасан нийгмийн даатгалын шимтгэлээс 36 сар хүртэлх хугацаанд, хэрэв ажилтан хөгжлийн бэрхшээлтэй бол 60 сар хүртэлх хугацаанд чөлөөлж болно. Хэрэв ажил олгогч 5 ажилтантай бол 3 ажилтны, 4 ажилтантай бол 2 ажилтны, 2 ба 3 ажилтантай бол 1 ажилтны ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөгдөнө. Энэ шимтгэлийн чөлөөлөлтөд даатгуулагч зөвхөн нэг удаа хамрагдана.”

Тайлбар:Сүүлийн таван жил гэдгийг ажил олгогч шимтгэлийн чөлөөлөлтөд хамрагдах хүсэлтээ нийгмийн даатгалын байгууллагад гаргасан сараас өмнөх 60

сарыг ойлгоно. Санал гаргасан Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо. Санал хураалт. Эхлээд гишүүд санал хураалтад бэлдэх юм байна шүү. Гишүүдээс санал хураалтдаа бэлтгээд, Хэрлэн гишүүнийх ороогүй байна, орсон уу одоо. Санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 24 гишүүн орсноос 14 гишүүн нь дэмжиж, санал 58.3 хувиар дэмжигдлээ.

2.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу санал хураалгах санал.

1/Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол

1.Нэгтгэсэн төслийн 2 дугаар зүйлийн 1 дүгээр зүйл болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх өдрөөс өмнө Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгосон 60 насанд хүрсэн эрэгтэй тэтгэвэр авагчид, 55 насанд хүрсэн эмэгтэй тэтгэвэр авагчид олгох суурь тэтгэвэр (C_T)-ийн хэмжээг тооцоход баримтлах үзүүлэлтийг Засгийн газраас тогтоохдоо Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг харгалзах бөгөөд суурь тэтгэврийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн олгоно.” Санал гаргасан Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо. Санал хураалт. Санал хураалтад нийт 24 гишүүн орсноос 14 гишүүн дэмжиж, санал 58,3 хувиар дэмжигдлээ.

2.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийг 2 дугаар зүйл болгож доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1.8 дахь заалтад заасан суурь тэтгэвэрт шаардагдах хөрөнгийг 2027 оны улсын төсөвт тусгана.” Санал гаргасан Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо. Санал хураалт. Санал хураалтад нийт 24 гишүүн орсноос 14 гишүүн дэмжиж, санал 58,3 хувиар дэмжигдлээ.

Сүүлийн санал хураалт. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол.

Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх өдрөөс өмнө Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгосон 60 насанд хүрсэн

эрэгтэй тэтгэвэр авагчид, 55 насанд хүрсэн эмэгтэй тэтгэвэр авагчид олгох суурь тэтгэвэр (C_T)-ийн хэмжээг тооцоход баримтлах үзүүлэлтийг Засгийн газраас тогтоохдоо Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг харгалзах бөгөөд суурь тэтгэврийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн олгоно.” Санал гаргасан Хүний хөгжил, нийгмийн хөгжлийн байнгын хороо. Санал хураалт. Санал хураалтад нийт 24 гишүүн орсноос 14 гишүүн дэмжиж, санал 58,3 хувиар дэмжигдлээ.

Өнөөдрийн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлууд дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Байгаа юм уу? Унших гишүүн байгаа билүү? Тийм. Булгантуяа гишүүн уншихаар, нэгдсэн чуулганы хуралдаанд Хэрлэн гишүүн танилцуулна Байнгын хорооны санал, дүгнэлтийг.

19.44 цаг

Ингээд орой болтол энэ чухал хуулиудыг хэлэлцэж, идэвхтэй хуралдаа суусан эрхэм гишүүддээ талархлаа илэрхийлье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА